# Баянхонгор аймгийн Засаг дарга Шинэжинст сумын Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээ хавсралт

### Шинэжинст сум ЗДТГ

### 2025 оны эхний хагас жил

| Д/д | Заалт | Арга хэмжээ | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Хүрэх түвшин, үр дүн | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1. Төрийн захиргаа, удирдлага зохион байгуулалт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд | 1.1. Шинээр санаачилсан арга хэмжээ | | 100 | Энэ жил 2 дугаар сарыг Малчид, төлчдийн сар, 3 дугаар сарыг Эмэгтэйчүүдийн сар, 4 дүгээр сарыг Төрийн албан хаагчдын сар, 5 дугаар сарыг Гэр бүлийн сар, 6 дугаар сарыг Хүүхдийн сар гэх мэт сар бүрийг нэрийн сар болгон зарлаж тухайн субъект рүү чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Жишээлбэл: 2 сард Малчид, төлчдийн зөвлөгөөн, 4 сарын 18-нд Төрийн албан хаагчдын зөвлөгөөн гэх мэт.<br><br>Хавсралт : 5 зураг | 70% |
| 2 | | 1.2. Нутгийн захиргааны байгууллагын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээг нэмэгдүүлэх | | 71.95 | Сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, сумын Хөгжлийн төлөвлөгөө, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг зэрэг бодолгын баримт бичгийг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн аймгийн хяналт шинэжилгээ үнэлгээний хэлтэсээс 2024 оны жилийн эцсийн Хяналт шалгалтын үнэлгээний зөвлөмж болон аймгийн Засаг даргатай сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэжгжилт, бусад бодолгын баримт бичгийн хэрэгжилийг хангаж төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. Хагас жилийн үнэлгээ 5%-иар нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна. Үнэлгээ хийгдэх хугацаа болоогүй хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна.<br><br>Хавсралт : 3 файл | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | | 1.3. Аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах | | 90.64 | Төсвийн байгууллагуудын удирдлагууд, багийн Засаг дарга нар, Тамгын газрын албан хаагчдад хамаарах заалтыг хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллах талаар үүрэг чиглэл өгч хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллахыг зөвлөж ажиллалаа. Мөн багуудын Иргэдийн нийтийн хурлаар гэрээг иргэдэд танилцуулж хийгдэж буй ажлын талаар танилцуулан ажилласан. Хугацаанд тайлагнаж хэрэгжилтийг нэгтгэн ажиллаж байна.<br><br>Хавсралт : 2 файл | 70% |
| 4 | | 1.4. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих, улирал бүр тайлагнах | | 95 | Хасас жилийн байдлаар Засаг даргын тамгын газарт 57 өргөдөл ирсэнээс 50 өргөдөлийг хугацаанд нь  Засаг дарга, холбогдох албан тушаалтан ХХК-д албан бичгээр хүргүүлж шийдвэрлүүлэн  ажилласан байна. 7 өргөдөлийн хугацаа болоогүй хянагдах шатандаа явж байна. Тайлан мэдээг 01 дүгээр улиралд 5 албан байгууллага Багийн Засаг дарга, ИТХ-ын ажлын албанаас авч нэгтэн аймгийн төрийн Захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлсэн бөгөөд 02 дугаар улирлын мэдээг авч нэгтэх ажил хийгдэж 25-ны дотор хүргүүлэн ажилллана.<br><br>Хавсралт : 1 файл | 90% |
| 5 | | 1.5. Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх /ISO/ | Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 11000000 төгрөг | 50 | Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ISO 9001:2015 Олон улсын стандартын байгууллагын "Чанарын менежментын тогтолцоо-шаардлага"-ыг Засаг даргын Тамгын газарт нэвтрүүлэх ажлыг эхлүүлж сумын Засаг даргын захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй “Чанарын баг” томилогдлоо. "Абсорб консалтинг" ХХК-ийн Зөвлөх, Аудитор Б.Алтансүхтэй хамтран Чанарын багийг арга зүйгээр хангах, чадавхжуулах сургалтыг зохион байгуулж байна.<br><br>Хавсралт : 3 зураг | 50% |
| 6 | 2. Гадаад харилцааны ажлын хүрээнд | 2.1. Байгаль орчны чиглэлээр Ниншя Хуйн ӨЗО-ны сайн туршлагыг хэрэгжүүлэх | Засаг даргын нөөцөөс 2 сая төгрөг | 20 | Ниншя Хуйн ӨЗО-ны Альшаа аймагт сумын Засаг дарга Л.Батхуяг 02 дугаар сарын 18-наас 22-ны өдрүүдэд оролцож туршлага судлан ажиллалаа. Тус уулзалтаар аймгийн Монгол уламжлалт эмнэлэг, Тэнгэрийн 8 сая квт-ын нарны эрчим хүчний төсөл, элс нутагшуулалт, салхины эрчим хүч, Сухайт гацааны Сая мүү заг модны суурин зэрэгт очиж танилцан туршлага солилцож ажилласан байна. | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хавсралт : 1 файл | |
| 7 | | 2.2. Сумын түвшинд хэрэгжүүлэх гадаад айлчлал, арга хэмжээ, уулзалт, байгуулах баримт бичгийн талаар удирдамж, чиглэл авч, илтгэх хуудас, ярианы тэмдэглэлийг хүргүүлж байх | | 1 1 1 | сумын хэмжээнд гадаад айлчлал хагас жилийн байдлаар хийгдээгүй байна | 30% |
| 8 | 3. Хүний нөөцийн бодлого төлөвлөлтийн хүрээнд | 3.1. Албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх | 850.000 төгрөг | 95 95 95 | Албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлж дотоод сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний дагуу шинээр томилогдсон албан хаагчдад албан хэрэг хөтлөлтийн стандартын сургалтыг 2 удаа, нийт албан хаагчдад үндэсний бичгийн цахим бичвэрийн сургалтыг 1 удаа орсон. Төрийн албан хаагчдын ажлын байран дээр суралцах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор ажилчдын дунд ном уншья аяныг өрнүүлж байгууллагын зардлаар сүүлийн үеийн шинэ ном хэвлэлийг захиалан ажиллаж байна. | 70% |
| 9 | | 3.2. Албан хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Хандив тусламж 650.000.000 төгрөг Ажилчдын цалингийн нэмэгдэлд 48.000.000 төгрөг Тоног төхөөрөмж худалдан авахад | 70 80 95 | Албан хаагчдийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд Тамгын газрын үндсэн ажилчдад Орон нутгийн нэмэгдлийг 80 хувиар тооцон сар бүр олгож 2025 оны сүүлийн хагас жилд босоо удирдлагатай бодлогын мэргэжилтнүүдийн цалинг мөн 80 хувиар тооцож нэмж олгохоор төсөвт тусган ажиллаж байна. Мөн тамгын газрын барилгын их засварыг сумын нутагт үйл ажиллагаа эрхэлдэг Эрдэнэ Монгол ХХК-ын нийгмийн хариуцлагын хүрээнд 650 сая төгрөгийн хөрөнгөөр 2025 оны 07-09 сарын хооронд хийж гүйцэтгэхээр зураг төсөв нь батлагдаж бэлтгэл ажлаа хангаж ажиллаж байна. Мөн албан хаагчдад нэн шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах зорилгоор байгууллагын төсөвт 20 сая төгрөг төсөвлөн 5 ажилтныг нөутбүүк болон шаардлагатай бусад тоног төхөөрөмжаар хангаж ажиллаж байна. | 80% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 20.000.000 төгрөг нийт 718 сая төгрөг | | | |
| 10 | | 3.3. Хүний нөөцийн судалгаа хийх | | 1 1 | Сумын хэмжээнд нийт 5 албан байгууллага руу албан бичиг хүргүүлж Хүний нөөцийн судалгааг авч "Эрдэнэ Монгол" ХХК-тай хамртан гэрээ байгуулж оюутан залуусыг Цалинтай оюутан хөтөлбөрт хамруулах бүртгэл ажил хийгдээд явж байна, бүртгэлийн хугацаа дуусаагүй байна.<br><br>Хавсралт : 2 файл | 50% |
| 11 | | 3.4. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх | | 100 | Ёс зүйн дэд хороог 5 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй хамт олны хурлаар хэлэлцэж Засаг даргын тамгын газрын даргын тушаалаар батлан ажилласан бөгөөд Ёс зүйн хороо нь нийт 4 удаагийн сургалт, 1 удаа нийт Төрийн албан хаагчдын зөвлөгөөн, 2 удаа төрийн албан хаагчдын дунд урлаг, спортын арга хэмжээ, 2 удаагийн хуулийн мэдлэг сорих тэмцээн, 1 удаа хайрцаг аялуулах ажлуудыг зохион байгуулж ажилласан нийт давхардсан тоогоор 400 гаруй албан хаагч хамрагдсан байна.<br><br>Хавсралт : 1 файл | 90% |
| 12 | 4. Байгууллагын ил тод байдлын хүрээнд | 4.1. Төрийн байгууллагын ил тод байдлыг хангаж, шилэн индексийн тайланг (shilen.gov.mn)-д улирал бүр илгээж, үнэлгээ хийлгэх | - | 95 | Төрийн үйлчилгээний оператор ажлын байранд 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн Г.Батчимэгийг томилж, цахимын ил тод байдлыг хариуцуулж ажиллаж байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан 98 төрлийн мэдээллийг “Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)”-д мөн https://shinejinst.bkh.gov.mn/ сайтад байршуулж байна. 2025 оны 01 дүгээр улирлын тайланг 03 дугаар сарын 31-ний өдөр буюу тайлант хугацаанд нь тайлагнан ажилласан байна. Төрийн үйлчилгээний оператор ажлын төлөвлөгөөнд 7 хоног болон сар бүрээр мэдээллийн самбар, сайтын мэдээллийг шинэчлэн ажиллаж байна.<br><br>Хавсралт : 1 зураг | 100% |
| 13 | | 4.2. Төрийн байгууллагын “gov.mn” нэгдсэн | | 50 | Төрийн үйлчилгээний оператор ажлын байранд 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн Г.Батчимэгийг томилж, цахимын ил тод байдлыг хариуцуулж ажиллаж байна. Байгууллагын Ил тод байдлыг сайжруулж, сумын сайт дээр ил | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | цахим хуудаст мэдээлэл байршуулах, тогтмол шинэчлэх | | | тод байхаар заагдсан 98 төрлийн мэдээг байршуулж байна. Мөн цахим сайтад цаг үеийн 8 мэдээ байршуулсан байна. Шинэжинст сум мэдээ мэдээллийн албан ёсны хуудаст нийт 103 мэдээ оруулсан байна. Үүнээс хөтөлбөрт үйл ажиллагааны зар 19, тайлан мэдээ 13-г оруулсан байна. Мөн видео мэдээ 7, цаг үеийн 38 мэдээ, орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн ажлын 3 мэдээ, засаг даргын тамгын газрын төсөвт хөрөнгөөс зарцуулсан ажлын 1 мэдээ, Зарын чанартай 18 мэдээ, Мэндчилгээ 2, Уриалга 3 тус тус байршуулан ажиллаж байна. Төрийн үйлчилгээний оператор ажлын төлөвлөгөөнд 7 хоног болон сар бүрээр мэдээллийн самбар, сайтын мэдээллийг шинэчлэн ажилладаг. | |
| 14 | | 4.3. Иргэдийн сэтгэл ханамжийн Irgen.Bayanhongor.gov.mn нэгдсэн системийн судалгаанд иргэдийг хамруулах, систем ашиглалтыг нэмэгдүүлэх | | 600 | Төрийн үйчлилгээ авч буй ард иргэдэд мөн сургалт зөвлөгөөн, урлаг спортын арга хэмжээний үеэр Irgen.Bayanhongor.gov.mn сайтаар нэвтэрч судалгаанд хамрагдахыг уриалж сумын хэмжээнд 100 гаруй иргэнийг хамруулан ажилласан | 70% |
| 15 | 5. Албан хэрэгцээний систем ашиглалтын хүрээнд: | 5.1. Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, шинэ тогтолцоонд шилжиж, албан бичгийг кирилл болон үндэсний бичгээр хөтөлж хэвших | Монгол бичгийн хэвлэмэл хуудас хэвлүүлэхэд 500000 төгрөгийн хөрөнгө зарцуулжээ. | 4 80 100 | Оны эхнээс Төрийн 6 байгууллага захирамж, тушаал, тогтоол, албан бичгийг крилл болон монгол бичгээр хослон хөтөлж эхлээд байна. | 50% |
| 16 | | 5.2. Албан бичгийн эргэлтийн “ERP” системийг албан хэрэгцээнд бүрэн ашиглаж хэвших | | 100 100 100 90 90 90 | Төрийн 6 байгууллага ERP программаар албан бичиг хүлээн авах, харилцагч байгууллагуудад явуулж программыг бүрэн ашиглаж хэвшсэн Засаг даргын Тамгын газар 368 бичиг хүлээн авч 101 бичиг программаар явуулсан байна. | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 17 | | 5.3. Албан бичиг боловсруулалтын e-office системийг бүрэн ашиглаж хэвших | | 100 90 90 90 | 2024 онд тус системийг ашиглан нэвтрүүлж эхэлсэн боловч аймгийн мэргэжилтэний ачааллаас хамаарч хяналтын шат удааширч хүлээгдэж байсан тул дотоод албан бичиг хяналтаар хяналтын дагалдах хуудсыг дагалдуулан ажиллаж байна. | 30% |
| 18 | 6. Гамшгийн үеийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд | 6.1. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, нэгдсэн дадлага сургууль зохион байгуулах | | 5 400 | Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу 3 дугаар сарын 27-ны өдрийн 16:00 цагт “ГАР ДУУТ ДОХИО”-г дуугаргахад “Цугларах цэг”-т Засаг даргын тамгын газрын 17, Ерөнхий боловсролын сургуулийн 29, Эрүүл мэндийн төвийн 9, Цэцэрлэгийн 8, Соёлын төвийн 5, нийт 5 байгууллагын 68 төрийн албан хаагч цугларлаа. Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний үүргэвчний бэлэн байдлыг шалгаж дадлага, сургалт зохион байгууллаа.<br><br>Хавсралт : 6 зураг | 90% |
| 19 | | 6.2. Сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах томилгоот мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг сургах, чадавхжуулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, | | 100 | Баянцагаан суманд зохион байгуулагдсан Гамшгаас хамгаалах команд штабын сургуульд Засаг даргын орлогч, 4 багийн Засаг дарга, Сургуулийн захирал, Цэцэрлэгийн эрхлэгч, Эрүүл мэндийн төвийн дарга, Соёлын төвийн дарга нар оролцож Гамшгаас урьдчилан сэргийлэх, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах аргачлал сургалтад хамрагдлаа. | 50% |
| 20 | 7. Хууль, эрх зүйн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд: | 7.1. Шинээр батлагдсан хуулиуд болон боловсруулж буй хуулийн төсөл, бусад холбогдох хууль тогтоомжийн талаарх сургалт, | 300.000 | 2000 50 | Байгууллагын хүрээнд эрх зүйн ажлыг сайжруулах чиглэлээр Байгууллагын мэдээллийн цагийг 7 хоног бүрийн Лхагва гарагт дотоод сургалтыг зохион байгуулж ажиллалаа. С Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухайн хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай, Малчдын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль зэрэг давхардсан тоогоор 15 удаагийн сургалтыг иргэд, төрийн албан хаагчдад орж, 2 удаагийн хуулийн сорилго тэмцээнийг амжилттай | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэлэлцүүлэг, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад тухай бүр дэмжлэг үзүүлэх | | | зохион байгуулж ажиллалаа. Мэдээллийн цагаар албан байгууллагын захирал, дарга, эрхлэгч болон төрийн албан хаагчид өөрсдийн ажил мэргэжлийн онцлогоос хамаарч шинэчлэгдсэн болон иргэдэд хэрэгтэй хууль тогтоомж, зөвлөгөө мэдээллийг нийт 15 удаагийн сургалт, 1 АХА тэмцээн, 1 нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж ажилласан байна. Давхардсан тоогоор 600 гаруй иргэд хамрагдсан байна<br><br>Хавсралт : 1 файл | |
| 21 | | 7.2. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхгүйгээр даган мөрдөж байгаа шийдвэрүүдийг хянан үзэж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх | | 2 | Хагас жилийн байдлаар 82 Захирамж, Тушаал 12 гарсан бөгөөд бүгдэд нь хяналтын дагалдах хуудсыг дагалдуулж хамгийн багадаа 3-4 албан хаагчаар дагалдах хуудсанд гарын үсэг зуруулж хянуулсаны дараагаар Захирамж, Тушаалыг гарган ажиллаж байна. Мөн аймгийн Хууль эрх зүйн хэлтэст 01 дүгээр улирлын Захирамжийг хянуулан ажилласан бөгөөд 2 дугаар улирлын захирамжийг хянуулахаар бэлтгэн ажиллаж байна. | 50% |
| 22 | | 7.3. Иргэд, хуулийн этгээдэд тоон гарын үсэг олгох ажлыг сумын хэмжээнд эрчимжүүлэх | | 80% | Иргэдэд, хуулийн этгээдэд тоон гарын үсэг олгох ажил 100%-д хүрсэн ажиллаж байгаач тоон гарын үсгээ мартах тохиолдол их гарч байна үүнтэй холбоотойгоор хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 172 тоон гарын үсгийг олгож ажилласан байна. | 90% |
| 23 | | 7.4. УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Хүний эрхийн үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2023 оны | | 100 | Хөтөлбөрийн төлөвлөөгөөг боловсруулан Гэр бүлийн тухай хууль холбогдох хуулиар сургалт мэдээллийг хүргэж ажилласан байна. 03 дугаар сард 200 гаруй өрхөөр орж гарын авлага, боршур тарааж Өрхийн айлчлалыг зохион байгуулж ард иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг сонсож үүнтэй холбоотойгоор ажил арга хэмжээг зохион байгууллан ажиллахаар төлөвлөн ажиллаж байна. | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 357 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан төлөвлөгөө, Засгийн газрын 2023 оны 231 дүгээр тогтоолоор батлагдсан төлөвлөгөөний хамаарал бүхий заалтын хэрэгжилтийг ханган ажиллах | | | | |
| 24 | | 7.5. Хэрэглэгчийн эрхийн хамгаалах тухай  хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах | | 5 | Хэрэглэгчийн эрхийн хамгаалах тухай хуулийн сургалтыг 10 ААН-д зохион байгуулж ажиллалаа. 03 дугаар улирлаас хяналт шалгалтыг хийхээр төлөвлөн ажиллаж байна. | 30% |
| 25 | | 7.6. Гэмт хэрэг, зөрчлийн тоог буурсан байх | | 377 | 200 гаруй ард иргэдэд сургалт мэдээллийг өгч ажиллаж. | 30% |
| 26 | | 7.7. Сумын хэмжээний архины хамааралтай иргэдийг архины эмчилгээнд хамруулж, ажлын | | 55 1 | Архины хамааралтай хүмүүсийн судалдгааг гаргаж архинаас татгалзах нөлөөллийн хүрээнд "Аз жаргалтай гэр бүл"- "Архинаас татгалзаж байна" прайм чэллэнж эхлүүлсэн. Мөн архины хамаралтай иргэдтэй уулзах уулзалтыг эхлүүлсэн. Дэлгүүр аж ахуй нэгжүүдэд архины худалдаатай холбоотой зөвлөмж өгч ажилласан. Аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран "Хайрлая-Хамтрая-Хэрэгжүүлье" өдөрлөгт арга хэмжээг зохион байгуулж Жаргалтай | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байраар хангах | | | амьдрал төвийн мэргэжилтэн үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл сургалт өгсөн.<br><br>Хавсралт : 2 зураг | |
| 27 | | 7.8. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангаж ажиллах | | 4 | багийн иргэдийн нийтийн хурлаар 200 гаруй иргэдэд гэмт хэрэг зөрчлийн талаарх мэдээллийг өгч ажилласан бусад ажил арга хэмжээг 09 сараас хийхээр төлөвлөн ажилллаж байна . | 30% |
| 28 | | 7.9. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж ажиллах | | 4 | Гэр бүлийн хүчирхийлллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хууль эрх зүйн сургалт арга хэмжээ 4 удаа, өрхийн айлчлал нэг удаа хийж 400 гаруй өрхөөр орж мэдээлэл сурталчилгаа хийсэн. Сэтгэл зүйчтэй уулзах уулзалт зөвлөгөө өгөх арга хэмжээнд 12 гэр бүлийн гишүүд хамрагдсан. Гэр бүлийн хөгжлийг дэмжих сарын арга хэмжээний хүрээнд Суралцагч гэр бүл төслийн хүрээнд 10 гэр бүлийн дунд уралдаан, сургалт арга хэмжээг зохион байгуулсан.<br><br>Хавсралт : 4 зураг | 70% |
| 29 | | 7.10. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангаж ажиллаж, малчдын бүлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан байх | | 5 | Багуудын Иргэдийн нийтийн хурлаар малчдад Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн зөвлөгөө, мэдээллийг өгсөн. Одоогоор энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.<br><br>Хавсралт : 2 зураг | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 30 | | 7.11. Хууль тогтоомжоор тогтоосон сумын Засаг даргын эрх хэмжээний асуудлаар аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дарга, сумын Хэсгийн төлөөлөгчтэй гурвалсан гэрээ байгуулан хагас, бүтэн жилээр биелэлтийг тооцож ажиллах | | 100 | Төлөөлөгч тэтгэвэртээ гарсан орны албан хаагч ирээгүй байгаа тул 3 гэрээ хүлээгдэж байна. | 30% |
| 31 | | 7.12. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтийг хангаж, үр дүнд хүргэж ажиллах | | 100 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 02 дугаар сард батлуулан 2 удаагийн сургалтыг зохион байгуулж 200 гаруй албан хаагч хаагч хамрагдаж 200 гарын гарын авлага боршурыг тарааж ажилласан энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил үйлдэгдээгүй ажиллаж байна. Бусад арга хэмжээг 09 дүгээр сараас хийхээр төлөвлөн ажиллаж байна. Тайланг хугацаанд нь Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлэн ажилласан байна. Төлөвлөгөөний биелэлтийг хавсралтаар оруулав<br><br>Хавсралт : 2 файл | 70% |
| 32 | | 7.13. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс | | 1 нэгжээр бууруулах | Нийт төрийн албан хаагчдын зөвлөгөөнийг 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж зөвлөгөөнд урилгаар аймгийн Засаг даргын тамгын газрын дарга, Хууль эрх зүйн хэлтэсийн дарга нарыг урьж авч ирэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх тухай хууль, Авлигын эсрэг хуулиудаар 115 албан хаагчдад сургалт орж зөвлөгөөний үеэр авлигаас ангид байх уриалга гаргаж | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ангид байх тухай хуульд заасан хориглолт хязгаарлалтыг мөрдөж ажиллах | | | ажиллалаа. Мөн аймгийн хууль эрх зүйн хэлтэсээс зохион байгуулсан сургалтад 23 албан хаагчийг цахимаар хамруулан ажилласан<br><br>Хавсралт : 3 файл | |
| 33 | | 7.14. Ажилтан бүрийн ажлын үр дүнг улирал, хагас, бүтэн жилээр дүгнэж урамшуулал олгохдоо албан хэргийн баримтжуулалт, стандарт хангалт, мөн заасан хугацаанд байгууллагын архивт баримтаа эмхлэн цэгцэлж цахим хувьтай бүрэн шилжүүлсэн байдал зэргийг харгалзан дүгнэж хэвших | | 100 100 | Албан хаагч бүрийн тайланг сар бүрийн 20-иор тайлангуулан ажиллаж хэвшээд байгаад бөгөөд хагас жилийн тайлан хэлэлцүүлэг 06 дугаар 26-ны өдөр зохион байгуулагдахаар төлөвлөн ажиллаж байна. Тайланд хийгдсэн ажил, арга хэмжээг харгалзан үр дүнгийн урамшууллыг хагас бүтэн жилээр олгон ажиллахаар төлөвлөж байна. Албан хаагч бүр өөр өөрсдийн ажил чиг үүргийн хүрээнд Захирамж, Тушаал гаргахдаа дагалдах хуудсын зуруулж хэвшил болгон ажиллаж байгаа бөгөөд архивын баримтыг 25-ны дотор хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна | 50% |
| 34 | | 7.15. “Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах 2023-2027 оны бодлого чиглэл”-ийг харьяа байгууллагууддаа | Энэ онд баримтын хавтас, хайрцаг авахад нийт 1095000 төгрөгийн хөрөнгө зарцуулав . | 1-3 20 | Засаг даргын Тамгын газар архивын баримт хадгалах тусгай байр гарган 6 нягтруулсан шүүгээ байршуулан 1994-2024 оны түр болон 70 жил хадгалах баримт, 2023-2024 оны байнга хадгалах баримтуудыг хавтаслан хайрцаглаж 100 хувь нягтруулсан шүүгээнд байршуулан хаяглан хадгалж байна.<br><br>Хавсралт : 2 зураг | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэх | | | | |
| 35 | | 7.16. Төрийн болон байгууллагын архивын баримтын цахимжуулалтын талаарх 2025-2028 оны аймгийн бодлого чиглэлийн хэрэгжилтийг хангаж байгууллагуудын үндсэн 2022 оны болон урьд шилжүүлээгүй тасалсан бусад оны баримтыг Төрийн архивд цаасан болон цахим хэлбэрээр дансны хамт бүрэн шилжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавих | Төрийн архивт баримт өгөхөд нийт 740700 төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна. | 100 100 | Засаг даргын Тамгын газар 148, Ерөнхий боловсролын дунд сургууль 57, соёл 36, цэцэрлэг 39, Эрүүл мэндийн төв 47 байнга хадгалах 2022 оны баримтуудыг цахим болон цаасан хэлбэрээр төрийн архивт дансны хамт бүрэн шилжүүлээд байна. | 100% |
| 36 | | 7.17. “Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх бодлого чиглэл”-ийг хэрэгжүүлэх, архив | | 100 50-80 | Төсвийн 6 байгууллагын архив бичиг хэргийн ажилтан нар мэргэшсэн 3-10 жил ажилласан туршлагатай албан хаагчид ажиллаж байна. Байгууллагууд үр дүнгийн урамшуулал болон орон нутгийн нэмэгдэл 40-80 хувиар бодож олгож байна. | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | бичиг хэргийн мэргэжилтэй, ажилтныг дэмжих, тогтвор суурьшилтай ажиллуулах орон нутгийн нэмэгдэл 80 хүртэлх хувиар олгох  зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах | | | | |
| 37 | 8. Боловсролын салбарын хүрээнд: | 8.1. Иргэнд тэгш хүртээмжтэй, чанартай боловсролын үйлчилгээг үзүүлэх / хавсралтаар / | | 100 | Хавсралт заагдсан 13 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 90% |
| 38 | | 8.1.1. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь | | 80 | Манай цэцэрлэг 2024-2025 оны хичээлийн жилд тойргийн хамран сургах 220 хүүхдээс нийт 159 хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг үзүүлэн ажилласан байна. Ингэснээр хамран сургалтын хувь 80%-д хүрсэн үзүүлэлттэй байна.  Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдсан хүүхдүүдийг насны ангиллаар харуулбал дараах байдалтай байна: • 2 настай хүүхэд – 25 • 3 настай хүүхэд – 30 • 4 настай хүүхэд – 30 • 5 настай хүүхэд – 45 • Явуулын бүлэгт хамрагдсан хүүхэд – 29 Эдгээр хүүхдүүдэд нас сэтгэхүйн онцлогт нь тохируулсан сургалтын агуулга, арга зүйгээр боловсролын үйлчилгээ үзүүлж, тэдний танин мэдэхүй, бие бялдар, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих зорилгоор үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлсэн.  Мөн явуулын бүлгийг хослуулан ажиллуулснаар алслагдсан баг, хөдөө амьдарч буй хүүхдүүдийг хамран сургах боломжийг нэмэгдүүлсэн. Явуулын бүлэг нь цэцэрлэгт тогтмол хамрагдах боломжгүй хүүхдүүдэд хүртээмжтэй үйлчилгээ үзүүлж, боловсролын тэгш хамралтыг хангахад чухал хувь нэмэр оруулсан. | 80% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 39 | | 8.1.2. 5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсрол хамрагдалтын хувь | | 90 | 2024-2025 оны хичээлийн жилд манай цэцэрлэг нь сумын хэмжээнд бүртгэлтэй 5 настай нийт 45 хүүхдийг 100% хамруулан, сургуулийн өмнөх боловсролын бэлтгэл бүлэгт сургалтын үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа. Эдгээр хүүхдүүд нь СӨБ-ын сургалтын агуулгын хүрээнд танин мэдэхүй, хэл яриа, тоо бодох, бичих, анхаарал төвлөрөл, нийгэмшихүйн болон өөрийгөө илэрхийлэх чадвар зэрэг суурь чадваруудыг эзэмшиж, ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангид элсэн суралцах бэлтгэл хангагдсан болно. | 100% |
| 40 | | 8.1.3. Цэцэрлэгийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж | | 86.5 | 2025 оны 4 дүгээр сарын 28-наас 5 дугаар сарын 03-ны өдрүүдэд манай цэцэрлэгт байгууллага болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулагдлаа. Уг үнэлгээ нь Боловсрол, шинжлэх ухааны яам, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар болон харьяа хяналтын байгууллагын удирдамж, журмын хүрээнд явагдсан болно. Үнэлгээнд • Нийт 89 хүүхэд – сургалтын чанар, хүүхдийн хөгжлийн үнэлгээний хүрээнд оролцсон • Нийт 5 багш – гүйцэтгэлийн үнэлгээний багц шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлгээнд хамрагдсан Гүйцэтгэлийн үнэлгээний эцсийн дүн, албан ёсны тайлан нь 2025 оны 8–9 дүгээр сард боловсруулагдан гарна. Үр дүнг үндэслэн цэцэрлэгийн цаашдын хөгжлийн бодлого, багшийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр, сургалтын агуулга сайжруулах төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх юм. | 60% |
| 41 | | 8.1.4. Сургуулийн өмнөх насны ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн СӨБ-д хамрагдалтын хувь | | 61 | 2024–2025 оны хичээлийн жилд манай цэцэрлэгт сургуулийн өмнөх насны тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хоёр хүүхэд бүртгэгдсэн бөгөөд тэдний боловсролын хэрэгцээнд нийцсэн, тэгш хамруулсан боловсролын орчинг бүрдүүлэн ажилласан. • 4 настай нэг хүүхдийг явуулын бүлгийн үйлчилгээ-д хамруулж, гэрээр нь очин тогтмол дасгал, даалгавар өгөх, хамтран гүйцэтгэх, хөгжлийн ахицад нь хяналт тавих байдлаар хүүхэд болон гэр бүлийн хэрэгцээнд нийцүүлсэн арга зүйгээр ажилласан. Ингэснээр хүүхдийн танин мэдэхүй, хөдөлгөөн, харилцааны чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн уялдаа холбоотой сургалт үргэлжлүүлэн зохион байгуулагдсан. • 5 настай нэг хүүхдийг цэцэрлэгийн үндсэн бүлэгт хамруулан, нас чацуу хүүхдүүдтэй харилцах, хамтран суралцах боломжоор хангаж, тэгш хамруулах боловсролын бодлогын хүрээнд хөгжлийн ялгаатай байдалд тохируулсан дэмжлэг үзүүлэн ажилласан. Багш нь тухайн хүүхдэд зориулсан тусгай арга зүй, хялбаршуулсан даалгавар, ажиглалт, урамшууллын аргуудыг хэрэглэж, хамтын сургалтын үр | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өгөөжийг нэмэгдүүлсэн. | |
| 42 | | 8.1.5. СӨБ-ын мэргэжлийн багшийн хангалтын хувь | | 100 | Манай бүлгийн багш нараас нэг нь Дарханы багшийн сургуульд суралцаж, СӨБ-ын багш мэргэжлийг эзэмшсэн. Харин бусад гурван багш нь багш мэргэжлээс хөрвөн, 2.5 жилээр суралцан СӨБ-ын багшийн мэргэжил эзэмшсэн. Одоогоор манай хамт олонд доод тал нь 5-аас дээш жил ажилласан туршлагатай, мэргэжлийн СӨБ-ын багш нар ажиллаж байна. | 100% |
| 43 | | 8.1.6. Стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин бүрдүүлсэн байх | | 100 | Манай цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын байгууллагад тавигдах стандартын шаардлагын хүрээнд нэг урсгалт зохион байгуулалт бүхий хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг бүрдүүлэн ажиллаж байна. Хоол үйлдвэрлэлийн хэсэг нь түүхий эдийн хүлээн авалт, боловсруулалт, хоол бэлтгэл, хадгалалт, тараалт зэрэг бүх шат дамжлагыг нэг чигийн урсгалаар, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулагдсан. Ингэснээр хүнсний аюулгүй байдлыг хангах, халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдсэн. Мөн “Эрдэнэ Монгол” компанийн хөрөнгө оруулалтаар үйлдвэрийн зориулалтын аяга таваг угаагч, аяга таваг ариутгагч зэрэг тоног төхөөрөмжийг гал тогоонд суурилуулсан нь цэвэрлэгээ, ариутгалын чанарыг сайжруулж, хүүхдийн эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хоол хүнсийг хүргэх боломжийг нэмэгдүүлж байна. Цаашид ч хоол үйлдвэрлэлийн орчинд эрүүл, аюулгүй, стандартын шаардлага хангасан нөхцөл бүрдүүлэн ажиллах зорилт тавин, мэргэжлийн байгууллагын заавар, хяналтыг тогтмол мөрдөж ажиллаж байна. | 80% |
| 44 | | 8.2.1. Ерөнхий боловсролын сургуулийн насны ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн ЕБ-д хамрагдалтын хувь | | 64 | Ерөнхий боловсролын сургуулийн насны ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хамрагдалт 63 хувьтай. | 70% |
| 45 | | 8.2.2. ЕБС-ийн мэргэжлийн багшийн хангалт | | 100 | Манай байгууллага нь нийт 22 багштай бөгөөд мэргэжлийн багшийн хангалт 95 хувьтай. | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 46 | | 8.2.3. Стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин бүрдүүлсэн байх | | сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэл стандартын шаардлагад нийцсэн байх | Хоол үйлдвэрлэл нь 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Орчны хувьд бэлтгэх, боловсруулах, цэвэрлэгээний гэсэн гурван зориулалтын өрөөтэй. Тоног төхөөрөмжийн хангалт 100 хувь, ашиглалт цахилгаан эх үүсвэрээс шалтгаалан 100 хувь хүрэхгүй байна. | 100% |
| 47 | | 8.2.4. Дунд, ахлах ангийн суралцагчдад эрүүл мэндийг дэмжсэн "Өглөөний цай", "Сүү" хөтөлбөрийг орон нутаг болон эцэг эхийн оролцоотойгоор хэрэгжүүлсэн байх /хувь/ | | 100 | Сүү хөтөлбөрт нийт 435 сурагч хамрагдаж байна. Бага боловсрол эзэмшигч 261 суралцагч үдийн хоолоороо, дунд ангийн 170 сурагч эцэг эхийн дэмжлэгээр сүү хөтөлбөрийг хэрэгжүүллээ. Сүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгаж батлуулсан. | 100% |
| 48 | | 8.2.5. Сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж | | 83 | Сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээнд 21 багш 420 сурагч хамрагдсан. Үнэлгээний дүн гараагүй байна. | 70% |
| 49 | | 8.2.6. Цахим сургалтад хамрагдах хүүхэд, цахим сургалт заах багш нарыг ажиллах нөхцөл боломжоор | | 100 | Цахим сургалт зохион байгуулах орчин нөхцөлийн хувьд тус сургууль ухаалаг самбар 7, таблет 120, суурин компьютер 8, зөөврийн компьютер 6 байна. | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хангасан байдал | | | | |
| 50 | | 8.2.7. Нэг компьютерт ногдох суралцагчийн тоо | | 8 | Нэг компьютерт ногдох суралцагчийн тоо 11 байна. | 70% |
| 51 | | 8.2.8. Эрүүл, аюулгүй сургуульд зарцуулсан мөнгөн дүн | | 80 | Байгууллагын галын аюулгүй байдлыг хангах үүднээс галын сараалж, 8 ширхэг галын хор авахад 1800000 төгрөгийг зарцуулсан. | 50% |
| 52 | | 8.2.9. Хүүхдийн төлөө орон нутгийн салбар зөвлөлийн дүрэмд "Эрүүл, аюулгүй сургууль" талаар зохицуулалт тусгасан эсэх | | 100 | Хүлээгдэж байгаа. | 30% |
| 53 | | 8.2.10. Амны хөндий-шүдний цоорлыг эрүүлжүүлсэн суралцагчийн тоо | | 100 | 2025 оны хичээлийн жилд нэгдүгээр ангийн 46 сурагчид шүдний үзлэгт хамрагдаж 44 сурагч шүдний өвчлөлтэй 2 сурагч эрүүл Эмчилгээ хийлгэсэн 2 сурагч Бусад 2-9 ангийн сурагчдыг 9 дүгээр сард үзлэгт хамруулахаар төлөвлөсөн. | 70% |
| 54 | | 8.2.11. Сургуульд эрүүл ахуйн шаардлага хангасан шүд угаах орчин (шүд угаах цэг) бүрдүүлсэн сургуулийн тоо / Шинээр 3-оос доошгүй / | | 3 | Шүд угаах ариун цэврийн байгууламж нь сургуулийн ариун цэврийн байгууламжаас тусдаа бөгөөд нийт 8 ширхэг угаалтууртай өрөө тохижуулан орчинг бүрдүүлсэн | 90% |
| 55 | | 8.2.12. Хүүхдийн | | 2 | Биеийн тамирын сургалтад хэрэглэдхүүн 1.100.000.00 Уралдаан тэмцээнд | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжпэг үзүүлэх үйлчилгээ /Зарцуулсан мөнгөн дүн/ | | | оролцоход 1.400.000.00 төгрөг зарцуулсан  Нийт аймаг бүсийн чанартай уралдаан тэмцээнд  давхардсан тоогоор 124 сурагч оролцсон байна | |
| 56 | | 8.2.13. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны орчин, нөхцөлийг сайжруулах, хуүхдийн хөгжилд дэмжлэг үзүүлэх /Дотуур байрны орчин, нөхцөлийг сайжруулахад зарцуулсан мөнгөн дүн, Хүүхдийн хөгжилд дэмжлэг үзүүлэх чиглэлээр зарцуулсан мөнгөн дүн/ | | 100 | Дотуур байрны хүүхдийн орчин нөхцөлийн хувьд зөөлөн эдлэлийг шинэчлэн сайжруулахад 100000000/Нэг зуун сая/ төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн. Дотуур байрны хүүхэд хөгжүүлэх төлөвлөөг 4 чиглэлээр 22 ажилтайгаар баталсан. Хүүхдүүдийн чөлөөлт цагийг зөв боловсон зарцуулахад нийт 20 удаа зохион байгуулж шагналт байранд шалгарсан сурагчдыг эцэг эхийн оролцоотойгоор урамшуулсан. Мөн гадна биеийн тамирын талбайд волейболын тор 1ш, бөмбөгийн тавиур  1 ширхгийг авахад 150000 төгрөг зарцуулсан. | 70% |
| 57 | | 8.2.14. Тухайн орон нутаг дахь МБСБ-ын төгсөгчийн хөдөлмөр | | 5 | Өлзийт МБС-ийг 14 иргэн төгссөнөөс 4 иргэн ажлын байраар хангагдсан. | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | эрхлэлтийн түвшин | | | | |
| 58 | | 8.2.15. "Суралцагч сум"-ын шаардлага хангахад төвийн үйл ажиллагаанд үзүүлсэн дэмжлэгийн хэмжээ | | суралцагч сум арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах | “Суралцагч сум”-ын төсөлт ажлын хэсгийг сумын Засаг даргын А47 дугаар захирамжаар 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.  Суралцагч байгууллага, гэр бүл, иргэн, хүүхэд гэсэн 4 чиглэлийн ажлыг холбогдох хүмүүст хариуцуулан ажлын төлөвлөгөө гаргаж сумын Засаг даргаар батлуулан ажиллаж байна. | 70% |
| 59 | | 8.2.16. Насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагааг дэмжиж, иргэн бүр насан туршдаа суралцах тэгш боломжийг бүрдүүлэхэд үзүүлсэн дэмжлэгийн хэмжээ | | 80 | Энэ хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрийн 4 суралцагч 9 дүгээр ангийг амжилттай төгсөж суурь боловсролыг эзэмшиж байна.  “Дижитал технологид суурилсан цахим контент, интерактив даалгавар боловсруулах” 10 цагийн сургалтыг сургуулийн удирдлагуудтай хамтран 22 иргэнд сургалт зохион байгуулсан.  canva дээр  5 иргэнд 4 цагийн | 90% |
| 60 | | 8.2.17. Хэлний бодлогын сумын салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн хувь | | 90 | Хэлний бодлогын салбар зөвлөлийг шинэчилэн байгуулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 50 хувьтай байна. Зөвлөлийн ажлыг Суралцагч сум төслийн ажилтай уялдуулан  Хос бичигтэн байгууллага шалгаруулах уралдааны удирдамжийг гарган хэрэгжүүлж байна. Хос бичгээр албан бичиг хөтлөх болсонтой уялдуулан бүх төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр явуулах талаар гол шалгуур болгосон.<br><br>Хавсралт : 2 файл | 50% |
| 61 | | 8.2.18. Өлзийт Мэргэжлийн боловсролын сургуультай хамтран “Хосмог сургалт”-ыг зохион | | 100 | Өлзийт МБС-ийг 3 чиглэлийн мэргэжлээр 19 иргэн суралцаж төгссөн. Дадлага хийх гэрээгээ байгуулан ажиллаж байна. | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулсан байдал | | | | |
| 62 | 9. Эрүүл мэндийн салбарын хүрээнд: | 9.1. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэхэд эрүүл мэндийн байгууллагыг дэмжин ажиллаж, иргэдэд чиглэсэн нөлөөллийн ажил зохион байгуулах | | 80 | Артерийн гипертензи, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг өвчнийг зохион байгуулж ажилласан. 2025оны эхний хагаст Артерийн гипертензи үзлэгт нийт 555 хүн хамруулсан, Чихрийн шижин үзлэгт 225 хүн хамруулж ажилласан. | 50% |
| 63 | | 9.2. Эрт илрүүлэг үзлэгээр илэрсэн шүдний өвчлөлийг эрүүлжүүлэх арга хэмжээ авч, Ерөнхий боловсролын сургуулийн 4,5,6 дугаар ангийн хүүхдүүдийн дунд “Шүд угаалтын аварга” шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах | 1,200,000 | 90 100 | Цэцэрлэгийн 2-5 хүртэлх насны 120 хүүхдэд шүд угаалтын хичээл орж, үзлэг хийн шүдний өвчлөлтэй 87 хүүхдэд шүдний хяналтын карт нээж давтан үзлэг хийн эмчлэн эрүүлжүүлэх талаар эцэг эхчүүдэд мэдээ мэдээлэл өгч ажилласан. Сургуулийн 4-6 ангийн хүүхдүүдэд 2 удаагийн давтамжтай шүд угаалтын сургалт хийж шүд угаалтын тестээр сорил авч шилдэг 36 хүүхдүүдийн дунд Шүд Угаалтын аврага шалгаруулах тэмцээнийг Сумын засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Соёлын төвтэй хамтран зохион байгуулж Эхний 3 байрын 9 хүүхдийн шагнаж урамшуулав.<br><br>Хавсралт : 3 файл | 90% |
| 64 | | 9.3. Эх, нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг | 0 | 0 | хагас жилийн байдлаар нялхасын эндэгдэл, 0-5 хүртэлх насны эндэгдэл бүртгэгдээгүй. | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | туушта́й бууруулах чиглэлээр тэгш хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээг орон нутгийн түвшинд зохион байгуулах, хяналт тавих | | | | |
| 65 | | 9.4. Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээ хэрэгжүүлж, халдварт өвчний тохиолдлыг бууруулах | | 13 95 | Сумын эрүүл мэндийн төв нь ард иргэдийн эрүүл мэндэд нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж өөрчлөлттэй гарсан иргэдийн шинжилгээг дээш нь 2шатлал руу явуулж эмчилгээнд нь бүрэн хамруулж хяналтанд авч ажиллаж байна. Сүрьеэгээр илэрсэн иргэдийг их эмч, багийн эмч нар хяналтандаа авч эм болон давтан шинжилгээг авч ажилладаг. | 70% |
| 66 | | 9.5. “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөн, “Эрүүл иргэн-Хонгорын баялаг” 2023-2026 арга хэмжээг сум орон нутагтаа өрнүүлэх, олон нийтэд “Эрүүл амьдралын хэв маяг” төлөвшүүлэх, дасгал хөдөлгөөн, зөв зохистой хооллолтыг дэмжих, архи согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, Монгол | Эрүүл иргэн хонгорын баялаг арга хэмжээний ажлын хүрээнд 650.000 төгрөг зарцуулсан. | 0 90 | Эрүүл иргэн хонгорын баялаг арга хэмжээний ажлын хүрээнд дараах ажлыг зохион байгуулсан. Ард иргэдийн дунд идэвхитэй дасгал хөдөлгөөн хийлгэсэн. Тогтмол 150-200 хүн дасгал хөдөлгөөнийг хийж хэвшсэн. Албан байгууллага бүр 11 цагт ажлын байрны дасгалыг хийдэг. Мөн архинд донтсон болон архины хамааралтай иргэдийн судалгааг гаргаж сургалтад хамруулсан.Сургалтад нийт 23 иргэн хамрагдсан. Ахлах ангийн 145 сурагчдад нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг олгосон. Мөн өсвөр насны 87 охидуудад сургалт орсон. Амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж шүдний цооролттой 120 сурагчийг 2-р шатлалын эмнэлэгт эмчлүүлэхийг зөвлөж ажилласан. Улаанбаатар хотоос шүдний эмч нар ирэхэд 21 хүүхдийг үзүүлж эмчилгээ хийлгэсэн. Өсвөр насны охидуудад хүсээгүй жирэмслэлт үр хөндөлтийн талаар сургалт хийсэн. Сургалтанд 85 сурагч хамрагдлаа. | 75% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хүнийг өвчлөхөөс урьтаж урьдчилан сэргийлэлтийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх | | | | |
| 67 | | 9.6. Иргэд олон нийтэд архины хамаарлын хор уршиг, түүнээс сэргийлэх, эрүүл амьдралын хэв маягийг сурталчлах соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, төсөв хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх | | Гүйцэтгэл ээр | Олон нийтэд архины хамраалын хор уршиг, түүнээс сэргийлэх эрүүл амьдралын хэв маягийг сурталчлах соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгууллаж үр дүнтэй ажилласан. | 50% |
| 68 | | 9.7. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутан залуусын эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх | | 371 | Эрүүл мэндийн даатгалаа төлөхөөр орж ирж байгаа иргэдэд E.Barimt, E.Mongolia ашиглуулан эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлүүлэн ажиллаж байна. | 90% |
| 69 | | 9.8. Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй хамтран орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг, сургалт, сурталчилгаа бусад | | 10 650 | Төрийн албаны хууль тогтоомжийг сурталчлан таниулах "Мэдээлэл сургалтын цаг"-аар 1 удаагийн сургалт зохион байгуулах ажлын зохион байгуулж мэдээлэл өглөө. Төрийн болон аж ахуй нэгж байгууллагын нийт 83 иргэд хамрагдлаа. Засаг даргын тамгын газраас 2025 оны 04 дүгээр сарын 28-29 өдрүүдэд “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгууллаа иргэд аж ахуй нэгж байгууллагуудад нийгмийн даатгалын тухай хууль болон иргэд малчид нийгмийн даатгалын сайн дурын хамрагдахын ач холбогдлын талаар биечлэн зөвлөгөөг нийт 48 иргэнд мэдээлэл өгч 5 иргэнд зөвлөмжийн хуудас бичиж | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | арга хэмжээг зохион байгуулах | | | өглөө. 1 иргэнээс өндөр настны тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэн авлаа. Аймгийн Засаг даргын 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн удирдамжийн дагуу “Хамтаръя–Хэрэгжүүлье–Хайрлая” өдөрлөгийг 5 дугаар сарын 26-ны өдөр Шинэжинст суманд зохион байгуулагдлаа. Өдөрлөгт нийгмийн салбарын 10 байгууллагын албан хаагч ажиллах бөгөөд өөр өөрийн салбарт хэрэгжиж байгаа арга хэмжээ, үйл ажиллагааны мэдээллийг холбогдох албан хаагчдад болон иргэдэд өгч ажиллалаа. Нийт 26 иргэн зөвлөгөө авлаа.<br><br>Хавсралт : 1 файл | |
| 70 | | 9.9. MNS6392:2013 “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага”, MNS7014:2023 “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” стандартуудын хэрэгжилтийг хангаж, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламжийн, ашиглалтад хяналт тавих, шаардлагатай урсгал болон их засварт дэмжлэг үзүүлэх | | Гүйцэтгэлээр 80 | MNS6392:2013 “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага”, MNS7014:2023 “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” стандартуудын хэрэгжилтийг хангуулж 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Эрүүлт мэндийн төвийн их засварыг хийж бүрэн ашиглалтад оруулсан. | 70% |
| 71 | | 9.10. ЭМС-ын 2024 оны "Хүний | | 90 | ЭМС-ын 2024 оны "Хүний папиллома вирусийн /ХПВ/ халдварын эсрэг вакинаар дархлаажуулах тухай" А/455 дугаар тушаалыг хэрэгжүүлж, ажилласан. Ерөнхий | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | папиллома вирусийн /ХПВ/ халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай" А/455 дугаар тушаалыг хэрэгжүүлж, вакцины хамралтад хяналт тавьж, эрчимжүүлж ажиллах | | | боловсролын сургуулийн 5-9 дүгээр ангийн 187 хүүхэд /ХПВ/-ын сургалтыг 5 удаа нийгмийн эрүүл ажилтан, вакцинатор, эрүүл мэндийн дарга нар зохион байгуулласан. Мөн Баянхонго аймгийн халдварт өвчин хариуцсан 2-р мэргэжилтэн ирж эцэг эх асран хамгаалгагчид сургалт хийсэн. ХПВ-ын дархлаажуулалтад 225 хүүхэд хамрагдахаас -160 хүүхэд хамрагдаж дархлаажуулалт 70% байна. | |
| 72 | | 9.11. “Эрүүл чийрэг эр хүн” аян зохион байгуулж, цэргийн насны эрчүүдийг эмчлэн эрүүлжүүлэх | | 150 80 | Эрүүл чийрэг эр хүн аян зохион байгуулж, цэргийн насны эрчүүдийг эмчлэн эрүүлжүүлж ажилласан. Мөн 2025 оны эхний хагаст 13 цэргийн насны залууст үзлэг хийж 8 цэрэг тэнцэж цэргийн албанд татагдсан. Эрүүл мэндийн шалтгаанаар тэнцээгүй 5 цэргийг эмчлэн эрүүлжүүлсэн. | 70% |
| 73 | | 9.12. “Жаргалтай амьдрал” СНСЗЭТ-ийн нөхөн сэргээх хөтөлбөрт хамруулах | | 3 | Жаргалтай амьдрал төвд манай байгууллагаас хамруулсан иргэд байхгүй. | 30% |
| 74 | 10. Хүний хөгжил, хүүхэд, гэр бүлийн салбарын хүрээнд: | 10.1. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудыг ажиллах нөхцөл боломжоор хангаж дэмжлэг үзүүлэх | | 1 Гүйцэтгэлээр | Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтнаар орон нутгийн мэргэжлийн боловсон хүчин Ш.Болормаа ажиллаж байна. Нийгмийн ажилтны ажиллах орчныг бүрдүүлэн ажлын компьютер, ширээ сандал зэргээр хангасан. Цаашид тусдаа өрөөнд суулгах боложмийг бүрдүүлэх шаардлагатай. | 70% |
| 75 | | 10.2. Аж ахуйн нэгжүүдэд шинээр “Эцэг эхийн зөвлөл” байгуулж, бодлогыг | | 5 5 | Шинээр Бизнес эрхлэгчдийн холбооны дэргэд Эцэг эхийн зөвлөлийг шинээр байгуулсан. Нийт эцэг эхийн зөвлөлтэй байгууллага 6 байна. Хүүхэд хамгааллын бодлоготой байгууллага 5 байна | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэх | | | | |
| 76 | | 10.3. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 57, 2025 оны 41 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангах, уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажиллахад хяналт тавих | | 1 30 0 | 5 сарын 1-ээс хойш 2 удаагийн морин уралдаан болсон бөгөөд 5 сарын 4-нд болсон Аймгийн бүсийн уралдааныг зохионг байгуулсан. Тус уралдааны уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж уралдаанч хүүхдүүдийн эцэг эхчүүд, уяачдад сургалт мэдээллийг өгсөн. 56 иргэн хамрагдсан. Уралдаанч хүүхдийг бүртгэн цахим мэдээллийн системд оруулсан. Бүртгэхдээ даатгал, эрүүл мэндийн үзлэг, эцэг эхийн зөвшөөрөл зэрэг холбогдох материалыг шаардаж бүртгэсэн. Уралдааны явцад хяналт шаардлагыг тавьж ажилласан бөгөөд унаач хүүхэд гэмтэж осолдоогүй болно. Нийт 56 унаач хүүхэд бүртгэгдсэн. | 70% |
| 77 | | 10.4. “Хүүхдээ сонсох өдөр”-ийн хэрэгжилтийг сайжруулах | | 320 85 | Хүүхдээ сонсох өдрийг сургуулийн түвшинд нэг удаа зохион байгуулсан бөгөөд сумын хэмжээнд 5 дугаар сард зохиогн байгуулахаар төлөвлөж хамтран ажиллахаар Ерөнхий боловсролын сургуульд санал тавьсан боловч сургуулийн үнэлгээ, шалгалт авагдаж байгаа гэсэн шалтгаанаар Хүүхдээ сонсох өдрийг зохион байгуулаагүй. | 50% |
| 78 | | 10.5. “Хүүхдийн нэгдсэн чуулган” зохион байгуулах | | 230 75 | Төлөвлөсөн хугацаа болоогүй тул хэрэгжээгүй | 30% |
| 79 | | 10.6. “Би ирээдүйн баялаг бүтээгч” хүүхдийн экспо үзэсгэлэн зохион байгуулах | | 1 80 | Хэрэгжүүлэх хугацаа болоогүй. Удирдамжийг танилцуулан төлөвлөсөн. | 30% |
| 80 | | 10.7. Хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж хүүхдийн хөгжил төлөвшил сайжруулах | 2 сая төгрөг Засаг даргын нөөцөөс. | 85 | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, дотуур байрны сурагчдад 2 удаа сургалт явуулж 85 хүүхэд хамрагдсан. Мөн ХГБХХГ-ын сэтгэл зүйчтэй хамтран сэтгэл зүйн зөвлөгөөг 65 хүүхдэд өгсөн. Соёлын төвтэй хамтран Хүүхдийн баярыг угтан үе тэнгийн дээрлэхэлт түүний хор уршгийг ойлгуулах агуулгаар "Буротино" жүжиг, урлагийн тоглолт, тэмцээн уралдаан зохион байгуулж шагнаж урамшуулсан. Мөн зорилтот бүлгийн 3 өрхийн хүүхдүүдийн амьжиргааг дэмжин | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хандив тусламж үзүүлсэн. | |
| 81 | | 10.8. Хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж хүүхдийн хөгжил төлөвшил сайжруулах | | 50 | Хамгааллын үйлчилгээнд 12 хүүхэд хамрагдсан байна. | 70% |
| 82 | | 10.9. Хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж хүүхдийн хөгжил төлөвшил сайжруулах | | 120 | Зорилтот бүлгийн хүүхдүүдээс дугуйлан секцэд хамрагдсан тоо 76 байна. | 50% |
| 83 | | 10.10. Хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж хүүхдийн хөгжил төлөвшил сайжруулах | | 5 | Зусланд хамрагдах хүүхдүүдийг бүртгэж байна. Одоогоор 4 хүүхэд бүртгүүлсэн хамрагдах ээлжийн хуваарь болоогүй. | 30% |
| 84 | | 10.11. Тогтвортой гэр бүлийг дэмжих бодлого хэрэгжүүлж, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах | | Гүйцэтгэлээр | Шинээр гэрлэлтээ батлуулсан 1 хос байна. | 70% |
| 85 | | 10.12. Тогтвортой гэр бүлийг дэмжих бодлого хэрэгжүүлж, гэр бүлийн хүчирхийллийг | | 300 37 | Гэр бүлийн хөгжлийг дэмжих сар, Суралцагч гэр бүл төслийн хүрээнд нийт 4 удаагийн сургалт, арга хэмжээ явуулсан бөгөөд давхардсан тоогоор 268 өрх хамрагдсан байна.<br><br>Хавсралт : 8 зураг | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | бууруулах | | | | |
| 86 | | 10.13. Тогтвортой гэр бүлийг дэмжих бодлого хэрэгжүүлж, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах | 22.1 сая төгрөг | 3.0 | Хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж зорилтот 3 өрхөд 5 ханатай гэр шийдвэрлэсэн. Зорилтот бүлгийн 90 хүүхдэд гарын бэлэг шийдвэрлэсэн. ХГБХХГ-аас 3 хүүхдэд 500000 төгрөгний хувцас, зусланд амрах эрхийн бичиг 360000, Зорилот 3 өрхөд 1 сая төгрөгний үнэ бүхий зүйл нийт 22.1 сая төгрөгийг хандив тусламж, хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд санхүүжилтийг шийдвэрлэсэн.<br><br>Хавсралт : 3 зураг | 70% |
| 87 | | 10.14. Тогтвортой гэр бүлийг дэмжих бодлого хэрэгжүүлж, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах | | 90 | Гэр бүлийн хүчирхийллээр бүртгэгдсэн 6 кейс нээж ажиллаж байна. | 50% |
| 88 | 11. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хүрээнд: | 11.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ажлын байр нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, ажилгүй иргэдийн судалгааг гарган, ядуурлын түвшнийг бууруулах, иргэдийн орлогыг | | 35 35 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн талаар ажилтан ажил олгогч, малчдад мэдээлэл, зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгааг хийж ажилласан. 2 удаа сургалт хийж 127 төрийн албан хаагч хамрагдсан. 297 малчин өрхөөр айлчилсан байна. Сумын хэмжээнд ажил идэвхтэй хайж буй 49 иргэний дэлгэрэнгүй судалгааг гаргасан. Байнгын ажлын байранд -5 түр ажлын байранд 11 нийт 16 иргэн ажлын байраар хангагдсан. | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлэх талаар оновчтой арга хэмжээ зохион байгуулж ажиллах, өрх бүрд ажлын байр бий болгох талаар дэмжиж ажиллах | | | | |
| 89 | | 11.2. Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон Ахмадын ордон, өргөө байгуулах, тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэн, Ахмадын өргөөг ахмад настан бүрд нээлттэй байх талаар анхаарч ажиллах | Засаг даргын нөөц хөрөнгөөс 2500000, аж ахуй нэгжийн дэмжлэгээр 10.000.000 төгрөг шийдвэрлэсэн. | 1 2.0 1230 | Ахмадын өргөөг ахмад настан бүрд нээлттэй байх талаар анхаарч ажиллах үүднээс ахмадын өргөөг хариуцуулан тогтмол ажиллуулж байна. Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний хүрээнд ахмад настнуудыг спорт зааланд тоглох цаг гаргаж өгсөн бөгөөд спортын чиглэлээр уралдаан тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлж нийт 2500000 төгрөгийг шийдвэрлэж өгсөн. Үүний үр дүнд нумт харваагаар бүсийн уралдаанд багаараа 2 удаа тэргүүлж Улсын мэргэн цолыг нэг ахмад тамирчин хүртсэн байна. Мөн говийн бүсийн сумдын ахмадуудын урлаг спортын наадмыг зохион байгуулахаар бэлтгэл хангаж байна. Үүнд шаардагдах төсвийг орон нутагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдийн нийгмийн хариуцлагын дэмжлэгээр шийдвэрлэсэн.<br><br>Хавсралт : 8 зураг | 90% |
| 90 | | 11.3. “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын хэрэгжилтийг | | 60 30 | Ахмад настны тухай хуулийн шинэчлэлийг танилцуулах сургалтыг Аймгийн ахадын хорооноос зохион байгуулж нийт 38 иргэд хамрагдлаа. Ахмадын сан байгуулах журмыг танилцуулж хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөгөө өгсөн. | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хангаж, нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжид тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | | | | |
| 91 | | 11.4. Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулах, ахмад настныг ажиллаж байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад сар бүр сургалт хийлгэх, ахлах ангийн сурагчид ахмад настанд технологийн, цахим орчин, цахим үйлчилгээний сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан оролцуулах, | | 10 100 60 | Ургийн бичиг хөтлөх, түүний ач холбогдол хэрэгцээний чиглэлээр Аймгийн нйигмийн бодлогын хэлтсээс зохион байгуулсан сургалтад ахмадын зөвлөлийн дарга хамрагдаж 7 сард зохион байгуулах өв соёлын арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан. Ахмад настны зөвлөх үйлчилгээний төсөлд 2 ахмад настан төслөө хүргүүлсэн байна. Тэтгэвэртээ гарсан ахмад настныг шаардлагатай сул орон тоонд ажиллах боломжийг хангаж нийт 3 ахмад настан төрий албанд эргэн ажиллаж байна. | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | урамшуулах | | | | |
| 92 | | 11.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл, сурталчилгааны ажлыг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, шаардагдах хөрөнгийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, орон нутгийн жил бүрийн төсөвт тусган, хэрэгжилтийг хангаж ажиллах | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асардаг асаргааны тэтгэмж 15 иргэнд 40956339₮ Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжинд 15 иргэнд 22172786₮ тус тус олгосон | 90 350 2.0 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хуулийг сурталчилан таниулах сургалтыг нэг удаа зохион байгуулж 75 иргэн хамрагдлаа. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах, ойлголт хандлагыг нэмэгдүүлэх үүднээс орон нутгийн цахим хуудсуудад постер мэдээллийг оруулж ажилласан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асардаг асаргааны тэтгэмж 15 иргэнд 40956339₮ Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжинд 15 иргэнд 22172786₮ тус тус олгосон | 70% |
| 93 | | 11.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах | | 4 360 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай хуулийн ойлголт мэдлэг өгөх сургалтыг зохион байгуулж 76 иргэн хамрагдсан. | 70% |
| 94 | | 11.7. Хөгжлийн | | 10 100 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээг хариуцсан эмчийг | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | бэрхшээлтэй иргэдэд Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл сургалт зохион байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, эмч, ажилтнуудыг чадавхжуулах сургалтад хамруулах | | 5 | томилон ажиллуулдаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг тогтмол үзүүлж байна. Сар бүр сургалт мэдээллийг өгч ажиллаж байна. Эмчээр Д.Нямцэрэн ажиллаж байна. Мэдээлэл сургалт, эрүүл мэндийн үйлчилгээнд нийт 56 иргэн хамрагдсан байна. | |
| 95 | | 11.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөрийг мэргэшсэн төрийн | | 21 3 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөрийг мэргэшсэн төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх үүднээс төрийн бус байгууллагатай холбоо тогтоож төлөвлөж байна. 3-р улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. | 30% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх | | | | |
| 96 | | 11.9. Төрийн үйлчилгээний байгууллагын гадна, дотор талын хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулж, төрийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, саадгүй болгох | | 6 300 | Төрийн үйлчилгээний байгууллагуудын үүд гадна талбайг хөгжлийн бэрхшээлэй иргэнд саадгүй, ээлтэй байлгах талаар, стандарт шаардлагыг хангаж ажиллахыг байгууллагуудын дарга нарт мэдэгдсэн бөгөөд шинээр хийгдэх засвар үйлчилгээндээ тусган хэрэгжүүлэхийг үүрэг болгосон. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, спорт заал, Засаг даргын тамгын газрын барилгуудад хийх засвараар дээрх шаардлагыг хангаж ажиллахаар байна. | 70% |
| 97 | | 11.10. Хүүхдийн төлөө зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, Жендэрийн дэд салбар хороо, Залуучуудын хөгжлийг дэмжих зөвлөл, ХАБЭА-н салбар зөвлөл, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, | Малчид төлчдийн зөвлөгөөн 18 сая төгрөг Засаг даргын нөөцөөс, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах сарын ажилд 5тсая төгрөг, Төрийн албан хаагдчын сарын ажилд 5 сая төгрөг, Гэр бүлийн хөгжлийн сард | 6 90 70 70 90 2 | Салбар дундын уялдаа холбоог хангах үүднээс сар бүр онцлог нэрэмжит ажлыг зохион байгуулахаар төлөвлөн хэрэгжүүлж байна. 2-р сар Малчид төлчдийн, 3 дугаар сар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, 4 дүгээр сар төрийн албан хаагчдын сар, 5 дугаар сар гэр бүлийн хөгжлийн, 6 дугаар сар Хүүхдийн эрх оролцооны, 7 дугаар сар өв соёлын, 8 дугаар сар Залуучуудын хөгжлийг дэмжих, 9 дүгээр сар Жижиг дунд үйлдвэрлэл өрхийн үйлдвэрлэлийн, 10 дугаар сар ахмад настны, 11 дүгээр сар охидын, 12 дугаар сар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдий гэх мэтээр төлөвлөн хөтөлбөр удирдамж гарган хэрэгжүүлж байна. Тус арга хэмжээг хэрэгжүүлэхдээ салбар бүрийн оролоoo хамтын ажиллагааг хангасан байхаар зохион байгуулж байна.<br><br>Хавсралт : 9 зураг | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл, Хэлний бодлогын салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, орон нутгийн шийдвэр гаргах түвшинд хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг нийгмийн бүлгүүд, иргэний нийгмийн байгууллагыг дэмжиж бодит оролцоог хангаж, салбар дундын уялдаа холбоог сайжруулах | 2 сая төгрөгийг, Хүүхдийн эрх оролцооны арга хэмжээнд 6 сая төгрөгийг тус тус зарцуулсан. | | | |
| 98 | | 11.11. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд | | 3.0 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт төлөвлөж, хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан Засаг даргын тамгын газрын барилгыг их засварт оруулахаар төлөвлөсөн бөгөөд шаардагдах төсвийг орон нутагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжийн хандив тусламжаар шийдвэрлэхээр болсон. | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт төлөвлөж, хэрэгжүүлэх | | | | |
| 99 | | 11.12. Нийгмийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах, хамралтыг нэмэгдүүлэх | 0 | 2 651 302 30 | 2025 оны эхний хагас жилд Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд нийт 215 даатгуулагч хамруулсны 170 нь “Малчин” байгаа нь сайн дурын даатгалд хамрагдаж байгаа иргэдийн 79%-ийг эзэлж байна. 2025 оны хагас жилийн байдлаар нийт Сайн дурын 215 даатгуулагчидтай гэрээ хийсэн. Үүнээс шинээр нийт 18 иргэнтэй сайн дурын гэрээ байгууллаа,Гэрээнд заасны дагуу төлөх шимтгэлийг тооцон авч 215 даатгуулагч хамруулж 2025 оны 06 дугаар сарын 13-ны байдлаар 210883055 төгрөгийн орлого оруулахаас 194275010 төгрөг хуримтлагдсанаар 92 хувиар биелүүлээд байна.  Эхийн 0-3 настай хүүхэд ээ асрах чөлөөтэй хугацааны тэтгэмжийн сангаас төлөх шимтгэлд 19 эхийг хамруулж эхний хагас жилд төлөвлөгөөнд 4036770 төгрөгийн орлого оруулахаас 3545880 төгрөгийг хуримтлагдсанаар 87% биелүүлээ.  Эхийн 0-3 настай хүүхэд ээ асрах чөлөөтэй хугацааны улсын төсвөөс төлөх шимтгэлд 16 эхийг хамруулж эхний хагас жилийн төлөвлөгөөнд 5166720 төгрөгийн орлого оруулахаас 3548050 төгрөгийг хуримтлагдсанаар 68 хувиар биелүүлээ.   Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй 9 эхийг хамруулж эхний хагас жилийн төлөвлөгөөнд 3651210 төгрөгийн орлого оруулахаас 4490640 төгрөгийг хуримтлагдсанаар 100 хувиар биелүүлээд байна.<br><br>Хавсралт : 1 файл | 90% |
| 10 0 | | 11.13. Сумын ахмадын хорооны даргыг төрийн байгууллагуудын ахмадуудтай харилцах үүрэгтэйгээр гэрээ байгуулж Хөдөлмөрийн | | 100 | Сумын ахмадын хорооны даргыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулж ажиллах төсвийг 2026 оны төсвийн төсөлд тусган төлөвлөсөн. 2026 оны 1 дүгээр сараас хэрэгжүүлж ахмадын хорооны даргын ажлыг хагас бүтэн жилээр дүгнэж ажиллахаар төлөвлөн ажиллаж байна. | 30% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хөлсний доод хэмжээгээр цалинжуулан ажиллуулж хагас бүтэн жилээр ажлыг үнэлэн үйл ажиллагааны үр дүнг дүгнэж ажиллах | | | | |
| 101 | 12. Жендэрийн эрх тэгш байдал, салбар дундын бодлого зохицуулалтын хүрээнд: | 12.1. Аймгийн ИТХ-ын 2023 оны 12.05-ны өдрийн 17/78 дугаар тогтоолын сумд хамааралтай заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах | | 80 | Хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг боловсруулан ажилласан байна. | 30% |
| 102 | | 12.2. Жендэрийн дэд салбар хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах, хяналт тавих | 5 сая төгрөг - хандив тусламж | 100 | Жендэрийн дэд салбар хорооны төлөвлөгөөний хэрэгжилтээр дэд салбар хорrг шинэчилж байгуулсан. 3 дугаар сарыг жендэрийн эрх тэгш байдлыг хангах сар болгон эмэгтэйчүүд эрэгтэйчүүдэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулсан. Хууль эрх зүйн сургал нэг удаа зохион байгуулсан. Сургалт арга хэмжээнд 120 гаруй иргэд хамрагдсан бөгөөд Оюуны соронз төвийн сургагч багш нар "Хайрлагдсан эмэгтэй", "Эрчүүдийг ачаа нь чимдэг" гэсэн сэдвүүдээр сэтгэл зүйн болон гэр бүлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан. Мөн үеэр "Хайрыг түгээе" Дэвжээ тэмцээнийг зохион байгуулж шагнаж урамшуулсан. Мөн олон нийтийн ойлголтыг өгөх, оролцоог хангах үүднээс спортын уралдаан тэмцээн зохион байгуулж дүгнэсэн. Тус арга хэмжээнд нийт 5 сая төгрөг зарцуулсан байна. Эрэгтэй эмэгтэй хүний дундаж наслалтыг зөрүүг багасгах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах талаар байгууллагуудын дарга нарт албан бичиг хүргүүлж биелэлтийг нэгтгэж тайлагнасан.<br><br>Хавсралт : 1 файл | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 103 | | 12.3. Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулж буй арга хэмжээнд оролцох | | 500 | Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор "Жендэрийн хариуцлагатай байгууллага шалгаруулах" уралдаанд оролцохоор удирдажмийг хүлээн авч ажлын төлөвлөгөөнд тусган хяналтдаа авсан. Мөн ISO9001:2025 Чанарын менежментийн станадртыг хэрэгжүүлэхтэй уялдуулан холбогдох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхлээд байна. | 50% |
| 104 | | 12.4. Сум, орон нутгийн бодлого төлөвлөлтөд жендерийн эрх тэгш байдлыг хангах талаарх заалт тусгах, төсөв хөрөнгө зарцуулах, дэмжин ажиллах | | 1.0 100 | Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, хөгжлийн төлөвлөгөөнд холбогдох заалтуудыг оруулсан. 3 сард болсон арга хэмжээнд 5 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.<br><br>Хавсралт : 1 файл | 70% |
| 105 | | 12.5. Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа нөлөөллийн аян, арга хэмжээг хэрэгжүүлэх | | 1000 | Жзндэрийн хорооноос бэлтгэсэн цахим сургалт 2, постер 3-ыг цахим хуудсанд хуваалцан байршуулсан. Мөн мэдээллийн цагаар нэг удаа сургалт мэдээллийг хүргэсэн. Хамрагдсан иргэдийн тоо 124.<br><br>Хавсралт : 2 зураг | 70% |
| 106 | 13. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын хүрээнд: | 13.1. Улс, аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нөхцөл байдлын үнэлгээ хийж, хадгалалт хамгаалалтыг сайжруулан иргэн, хуулийн этгээдэд | Хөрөнгө зарцуулаагүй | 4 10 | Түүх соёлын дурсгалт газруудтай малчид, сумын засаг дарга соёлын төв гэсэн гурвалсан гэрээ байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 30% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | гэрээгээр хариуцуулах ажлыг зохион байгуулах. | | | | |
| 107 | | 13.2. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын анхдугаар чуулган уулзалт, зөвлөгөөнд өвлөн уламжлагчдаа оролцуулах | Хөрөнгө зарцуулаагүй | 7 | Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын зөвөлгөөн, чуулган, уулзалт аймгийн хэмжээнд төлөвлөгдсөн боловч зохион байгуулагдаагүй байна. | 30% |
| 108 | | 13.3. Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах сургалтад үе шаттай хамрагдах | Хөрөнгө заруулаагүй | 5 | Хангайн бүсийн музей ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх "Музейн үзүүллэг дэглэлт" дадлага сургалт Булган аймгийн Булган хотод 5-н сарын 16-наас 5-н сарын 18-ны хооронд зохион байгууддагдсан сургалтад Соёлын төвийн өвийн бүртгэл мэдээллийн санч Г.Сонор хамрагдан "Сертификад" авсан. | 90% |
| 109 | | 13.4. Соёл, урлагийн салбарт шилжин, суурьшин ажиллаж байгаа албан хаагчдыг дэмжиж ажиллах | | 2 | Улаанбаатар хотод ажиллаж байгаад нутаг орондоо ажиллаж амьдрахаар ирсэн 1 иргэний хүсэлтийг шийдвэрлэж Соёлын төвийн техникчийн ажилд томилон ажиллуулж байна. | 70% |
| 110 | | 13.5. "Соёлтой Баянхонгорчууд" арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган | ЗДТГ зарцуулсан хөрөнгийг хариуцаж ажиллаа. | 7 100 1300 | Соёлтой Баянхонгорчууд арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор төрийн алба хаагчдын нэгдсэн зөвөлгөөний үеэр "Соёлтой боловсон, ёс зүйтэй" төрийн алба хаагч нэгдсэн уриалгийг гарган Баянхонгор аймгийн ЗДТГ-ын дарга, Төрийн албаны салбар зөвлөлийн дарга Д.Энхжаргал, Баянхонгор аймгийн хууль эрх зүйн хэлтэсийн дарга, Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүн Д.Сарангарав нар урилгаар ирж ёс зүй, харилцаа хандлага сэдвээр лекц сургалтыг зохион байгууллаа. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилтийг хангаж, соёлын үйл ажиллагааг өргөжүүлэх | | | | |
| 111 | | 13.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүүхэд, ахмад настан соёл урлагийн үйлчилгээ авах ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлэх | Хөрөнгө зарцуулаагүй | 100 | Хүүхдийн төлөө үндэсний зөвлөйийн гишүүн сургагч багш Д.Ундраа-Үжингийн сургалтад хамрагдан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тав тух, орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр зөвөлгөө авч ажиллаж байна. | 30% |
| 112 | | 13.7. Соёлын орон зайг бүрдүүлж бүтээлч гудамж бий болгох /Street art/ | | 100 | Тус хэрэгжилтийн хүрээнд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулан 08 дугаар сард хийгдэхээр төлөвлөн ажиллаж байна. | 30% |
| 113 | | 13.8. Иргэд, олон нийт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх зориулалтын зам, талбайг нэмэгдүүлж, орчин нөхцөлийг сайжруулах | Орон нутгийн хөгжлийн сангийн 1412471400 төгрөг | 100 | Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр биеийн тамирын гадаа талбай байгуулах тендер зарлаж гүйцэтгэгчээр “Элбэг констракшн” ХХК шалгаран 1412471400 (нэг тэрбум дөрвөн зуун арван хоёр сая дөрвөн зуун далан нэгэн сая дөрвөн зуу) төгрөгөөр хүүхэд багачууд, иргэд, олон нийт спортоор хичээллэх зориулалтын дугуйны зам, стандартын хөл бөмбөгийн талбай, сагс, волейболын талбай, ширээний теннис, идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх тоног төхөөрөмжүүд бүхий Спорт, цэцэрлэгт хүрээлэн байгуулах бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна. Гэрээний хугацаа 06 дугаар сарын 30-ны өдөр дуусах ба гүйцэтгэл 95%-тай.<br><br>Хавсралт : 5 зураг | 100% |
| 114 | | 13:9. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх иргэдийн | 1000000₮ | 20 1000<br>100 300 | Баянхонгор аймгийн насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах ҮНДЭСНИЙ БӨХИЙН БАРИЛДААН ", Шинэжинст сумын “Залаагийн хүчтэй” бөхийн дэвжээний нээлт тус суманд 2025 оны 05 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Өв соёл, үүх түүхээрээ бахархдаг Улсын арслан Э.Оюунболд, Улсын начин Баянхонгор аймгийн Жинст сумын уугуул | 80% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тоог нэмэгдүүлэх | | | Б.Батмагнай нар алслагдсан энэ суманд урилгаар очиж, сумынхаа наадамд 11 түрүүлж, 4 үзүүрлэсэн Лодойн Бүлтэг агсны алдрыг олонд таниулсан улс, аймгийн цолтой үндэсний бөхийн барилдаанд зодоглов. Улсын алдар цолтой эдгээр бөхчүүд Шинэжинст сумын “Залаагийн хүчтэн” бөхийн дэвжээний нээлтэд ирж зодоглож буй нь энэ нутгаас улсын цолтон төрөн гарна хэмээн нутгийн иргэд ихэд билэгшээж байлаа. Ийнхүү /2025.05.20/ улс аймгийн цолтой хүчит бөхийн барилдаанд 40 гаруй бөх барилдсанаас шөвгийн дөрөвт Улсын арслан Э.Оюунболд, Улсын начин Э.Батмагнай, Аймгийн арслан Ч.Алтангэрэл, Аймгийн начин Э.Бямбадорж нар шалгарав. Улмаар үзүүр, түрүүнд зүүн болон баруун жигүүрийг манлайлан барилдсан Улсын арслан Э.Оюунболд, Улсын начин Э.Батмагнай нар үлдэж, Улсын начин Э.Батмагнай түрүүллээ.<br>"ЭРТНЭЭС СЭРЭМЖЛҮҮЛЭХ ТОГТОЛЦООНД УЧРАХ СААД БЭРХШЭЭЛИЙГ ХАМТДАА ШИЙДЭЦГЭЭЕ ЗӨВЛӨГӨӨНИЙ<br>СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ 5 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд 2 өдрийн турш зохион байгуулагдаж, 19 сумын 104 төрийн албан хаагч оролцлоо.<br>БАЯНХОНГОР АЙМАГ ГОВИЙН БҮСИЙН УРЛАГ СПОРТЫН ТЭМЦЭЭН<br>Баянхонгор аймгийн Говийн бүсийн 9-н сумын ИТХ, Засаг даргын Тамгын газрын хамт олны дунд зохион байгуулсан Урлаг спортын 13 төрөлт тэмцээнд амжилттай оролцож нийлбэр дүнгээр Шинэжинст сум Дэд байр эзэллээ. Секц дугуйлан хичээллүүлж байна. Волейболын дугуйланд 6-9 насны 25 хүүхэд, 10-14 насны 32 хүүхэд хамрагдаж байна. Мөн ширээний теннисны дугуйлан 25 сурагч хүүхдүүд хамрагдсан. Ажлын байрны дасгал хөдөлгөөнийг байгууллага дээр нь өдөр болгон хийлгүүлж өдөр болгон мэдээллийг Эрүүл Иргэн-Хонгорын баялаг 2025 оруулж ирц бүртгүүлдэг. . Ажлын байрны дасгалд 120 албан хаагчид хамрагдсан байна.<br><br>Хавсралт нийт : 7 Файл : 1 Зураг : 6 | |
| 115 | 14. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, ашиг | 14.1. Сумдын ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасгийг 3 орон тоогоор ажиллуулах | | 3 | Тус сумын Хөдөө аж ахуйн тасаг нь Малын үржил, бүртгэл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн Б.Ганбат, Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн Ж.Одонжаргал гэсэн 2 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Хүнс, хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэний орон тоог зарласан боловч шаардлага хангасан мэргэжилтэн байхгүй сул орон тоотой байна. | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 116 | шимийг нэмэгдүүлэх хүрээнд: | 14.2. Аймгийн Засаг даргын тэтгэлгээр Хөдөө аж ахуй, мал эмнэлгийн чиглэлээр суралцаж буй суралцагчдын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих | | 1 | Тус сумын Уртын гол 2 дугаар багийн иргэн Амартүвшингийн Түвшинзаяа нь аймгийн Засаг даргын тэтгэлгээр Хөдөө аж ахуйн их сургуульд Мал зүйч мэргэжлээр суралцан 5025 оны 6 дугаар сард төгссөн. | 100% |
| 117 | | 14.3. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийн хангах | | -50 -30 | 2024-2025 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэлийг хангах ажлыг орон нутагт сайтар зохион байгуулах шаардлагад үндэслэн сумын аюулгүй нөөцөд 29 тн тэжээлийг татан авч нөөцлөсөн болно.Мөн отор нүүдлийг эртнээс зохион байгуулах ,өвөлжөө бууцыг чөлөөлөх талаар багуудын Иргэдийн нийтийн хурлаар зөвлөмж зөвлөгөө өгч ажиллаж байна | 50% |
| 118 | | 14.4. Тариалалтын хэмжээг нэмэгдүүлж 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах (нэгдүгээр хавсралтаар) | | 869 3454 | Төмс 1 га, манжин 0.21 га, хүрэн манжин 0.23 га, лууван 0.58 га, өргөст хэмх 0.13 га, лооль 1.09 га, халуун чинжүү 0.13 га, сонгино 0.39 га, сармис 0.01 га, газрын алим 0.75 га, амтат гуа 0.51 га, шийгуа 0.12 га, лидэр 0.03, гүргэм 0.03 га-д нийт 5.21 га талбайд 19 өрх 1 хоршоо тариалалт хийсэн.<br><br>Хавсралт : 1 файл | 70% |
| 119 | | 14.4.1. 2025 онд тариалах талбай, га-гаар | | 20 5 2 5 1.0 | Төмс 1 га, манжин 0.21 га, хүрэн манжин 0.23 га, лууван 0.58 га, өргөст хэмх 0.13 га, лооль 1.09 га, халуун чинжүү 0.13 га, сонгино 0.39 га, сармис 0.01 га, газрын алим 0.75 га, амтат гуа 0.51 га, шийгуа 0.12 га, лидэр 0.03, гүргэм 0.03 га-д нийт 5.21 га талбайд 19 өрх 1 хоршоо тариалалт хийсэн.<br><br>Хавсралт : 1 файл | 70% |
| 120 | | 14.4.2. Хураан авах ургац тн-оор | | 11 16 33 0.9 | Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй. Төмс 1 га, манжин 0.21 га, хүрэн манжин 0.23 га, лууван 0.58 га, өргөст хэмх 0.13 га, лооль 1.09 га, халуун чинжүү 0.13 га, сонгино 0.39 га, сармис 0.01 га, газрын алим 0.75 га, амтат гуа 0.51 га, шийгуа 0.12 га, лидэр 0.03, гүргэм 0.03 га-д нийт 5.21 га талбайд 19 өрх 1 хоршоо | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тариалалт хийсэн. | |
| 121 | | 14.5. Атаршсан газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр арга хэмжээ авах | | 1 1 1 | Газрын нэгдсэн системд сумын хэмжээнд атаршсан газар нийт 9 га талбай бүртгэлтэй байгаа боловч газрын байршил координат нь тодорхойгүй. | 30% |
| 122 | | 14.6. Өвөлжөө бууцны хөлд малын тэжээлийн ургамал тариалах | | 10% | Хаврын тариалалт хийгдэж дуусаагүй. Одоогоор өвөлжөө, хаваржааны бууцны хөлд тэжээлийн ургамал тариалсан өрх байхгүй. | 30% |
| 123 | | 14.7. Таримлын үрийн чанар, аюулгүй байдалд хяналт тавих | | 2 | 3 дугаар сард нөөцөд бэлтгэсэн үрэнд хяналт шалгалтыг хийсэн. Эхийн гол, Уртын голын талбайд тариалалт хийдэг тариаланчид маань хүнсний ногоо, жимс, жимсгэний үрийн нөөцийг өмнөх ондоо бэлтгэн авч дараа жилийн тариалалтаа хийдэг. Мөн эхийн голын тариалан эрхлэгч З.Олонбаяр, Х.Алтанцэцэг нар нь улсад үр нийлүүлдэг. Энэ онд гаднаас таримлын үр аваагүй. Тариалалтанд бэлтгэсэн үрийн нөөцийг технологийн дагуу аюулгүй хадгалаж энэ хаврын тариалалтаа хийсэн.<br><br>Хавсралт : 5 зураг | 70% |
| 124 | | 14.8. Монгол Улсын Засгийн газар, Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Цагаан алт”, “Шинэ хоршоо-чинээлэг малчин”, “Хүнсний хувьсгал”, “Атарын IV аян” зэрэг үндэсний хөдөлгөөн, хөтөлбөрүүдийг сумын өрх бүрд | | 2 300 | "Шинэ хоршоо-Чинээлэг малчин"," Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөн", "Атар IV аян", “Цагаан алт”, хөтөлбөрийн хүрээнд нийт 4 удаагийн сургалт зохион байгуулсан. Давхардсан тоогоор нийт 300 гаруй иргэн хамрагдсан. | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хүргэж, сурталчлан таниулах | | | | |
| 125 | | 14.9. Монгол Улсын Засгийн газар, Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Цагаан алт”, хөтөлбөрийг сумын өрх бүрд хүргэж, сурталчлан таниулах | | 2 300 | Монгол Улсын Засгийн газар, Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Цагаан алт”, хөтөлбөрийн хүрээнд бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн 2 удаагийн цахим сургалтанд хамрагдсан. Мөн "Цагаан алт" үндэсний хөдөлгөөний хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, ажлын төлөвлөгөө, хэрэгжилт, оролцогч талуудын уялдаа холбоо PPT-ээр 2 удаагийн сургалт зохион байгуулсан. Сургалтанд давхардсан тоогоор 80 гаруй иргэн хамрагдсан. Сумын хэмжээнд ноос, ноолуурын чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулж буй хоршоодын судалгааг гаргаж дээд шатны байгууллагад хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 2 файл | 50% |
| 126 | | 14.10. “Шинэ хоршоо-чинээлэг малчин” хөдөлгөөн хэрэгжүүлэх | | 2 10 - | "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2 удаагийн сургалт арга хэмжээ зохион байгуулагдсан. Тус хөдөлгөөний хүрээнд 8 хоршоо шинээр байгуулагдсан. Үүнээс 6 хоршоо нийт 608 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.<br><br>Хавсралт : 2 файл | 90% |
| 127 | | 14.11. “Хүнсний хувьсгал”,үндэсний хөдөлгөөнийг сумын хэмжээнд хэрэгжүүлж ажиллах | | 2 | Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөний хүрээнд суманд үйл ажиллагаа тогтмол явуулдаг дэлгүүр, зоогийн газар, караоке зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарт 2 удаагийн сургалт орж гарын авлага тараасан. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний эрүүл ахуйн улсын байцаагч н.Балдангомботой хамтарсан шалгалтыг 1 удаа зохион байгуулж хугацаа дууссан хүнсий бүтээгдэхүүнийг хурааж Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг устгалд оруулсан. Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн байцаагч нарын хяналтад мөн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарыг хамруулж шаардлагатай бичиг баримтын бүрдлийг шалгууллаа. | 50% |
| 128 | | 14.12. “Атарын IV аян”-ыг хэрэгжүүлж | | 2 | "Атар IV аян" хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн улсын зөвлөгөөнд тус сумын тариаланч Т.Батжаргал оролцсон. Баянхонгор аймгийн тариаланч, ногоочдын нэгдсэн зөвлөгөөн 2025” арга хэмжээнд сумын Бэлчээр, газар | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллах | | | тариалан хариуцсан мэргэжилтэн таван тариаланчийн хамт оролцон өөрт тулгамдаж буй асуудал, тариаланчдын туршлага зэргээсээ хуваалцан санал бодлоо солилцсон.<br><br>Хавсралт : 4 зураг | |
| 129 | | 14.13. Малын удмын санг хамгаалах, ашиг шим, үүлдэрлэг байдалд хяналт тавих | | 2 | Мал сүрэгт үзлэг ангилалт хийж ашиг шимийн түвшин тогтоох ажлыг сумын Засаг даргын захирамжийн дагуу аймгийн Хүнс,Хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн албаны мэргэжилтнүүдийн хамт 2025 оны 05 дугаар сарын 05 -ны өдрөөс эхлэн мал аж ахуйн 3 багт 4046 толгой Залаажинст-Эдрэн үүлдрийн ямаан сүргийг хамруулан зохион байгууллаа. | 50% |
| 130 | | 14.14. Малын чанар, үүлдэр угсааг сайжруулах зорилгоор зохиомол хээлтүүлэг хийх ажлыг төлөвлөн шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг батлуулах | | 20,0 | Хөрөнгийн эх үүсвэрийг төсвийн тодотголд тусгуулахаар ажиллаж байна | 30% |
| 131 | | 14.15. Өвөл, хаврын улирлын бэлчээрийн даац, зудын эрсдэлийн зураглалыг цаг агаарын мэдээнд тулгуурлан бодитой тогтоох, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилсан сэргийлэх мэдээг малчид, иргэдэд | | 1 1 | Өвөл, хаврын улирлын бэлчээрийн даац, зудын эрсдэлийн зураглалыг цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилсан сэргийлэх мэдээг цаг тухай бүрд нь сумын нэгдсэн цахим хуудас болон багуудын цахим хуудас, Засаг даргын тамгын газрын мэдээллийн самбар зэрэгт байршуулан малчид, иргэд олон нийтэд нээлттэй ил тод мэдээллэж байна. Сумын хэмжээнд бэлчээрийн даацыг тодорхойлох фотомониторингийн ажлыг жил бүрийн 8 дугаар сард хийж бэлчээрийн даацыг тодорхойлдог.<br><br>Хавсралт : 3 зураг | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | түргэн шуурхай, цаг алдалгүй хүргэх, цаашдын бодлого төлөвлөлтөд тусгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | | | | |
| 132 | | 14.16. Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг эдийн засгийн эргэлтэд оруулах; | | 50,0 | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. | 30% |
| 133 | | 14.17. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх; | | 3 | Шинээр уст цэг гаргаагүй. Эрдэнэмонгол ХХК-ын зам дагуух “ЗҮҮН УС”-ны худаг, "БАРУУН УС"-ны худагуудыг иргэд, орон нутгийн удирдлагуудын хүсэлтийн дагуу Эрдэнэмонгол ХХК өөрийн хөрөнгөөр стандартад нийцсэн хамгаалалт бүхий барилга байгууламжийг барьж уст цэгийг сэргээн засварлан сумын иргэд болон удирдлагуудаас бүрдсэн ажлын хэсэгт хүлээлгэн өглөө.<br><br>Хавсралт : 4 зураг | 70% |
| 134 | | 14.18. Мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулж, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг | Үхэр дархлаажуулах зардалд 338600 төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөнөөс шийдвэрлүүлэн зарцуулсан. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | 3,0 | Тус сумын үхэр сүргийг "Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтыг зохион байгуулах тухай" аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/255 дугаар захирамжийн дагуу сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/68 тоот захирамжийг боловсруулан батлуулж хавсралтаар ажлын хэсэг, зардлын тооцоог шийдвэрлүүлэн ажиллалаа. Нийт маршрутын дагуу 599 км явах 338600 мянган төгрөгний зардлыг сумын Засаг даргын нөөц хөрөнгөнөөс шийдүүлэн 2 чиглэл болон явсан. Сумын нутаг дэвсгэрт байгаа 34 өрхийн 255 үхэр сүргийг бүрэн хамруулсан. Дархлаажуулалтад үхэр сүргийг 05 дугаар сарын 19,20,21 ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Мөн "Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай" аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/232 тоот захирамж, Мал эмнэлгийн газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/21 тоот тушаалын дагуу 2025 оны төлөвлөгөөт дархлаажуулалтыг зохион байгуулан | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хангах, зохион байгуулах | дархлаажуулалтын зардлыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж хариуцан вакцинжуулж байна. | | ажиллаж байна. Энэ онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 7 төрлийн дархлаажуулалтыг технологит хугацаанд нь вакцинжуулалтанд хамруулж байна. Хагас жилийн байдлаар Шөвөг яр, Коли иж балнадын дархлаажуулалтад 5000  толгой мал хамрагдаад байна. | |
| 135 | | 14.19. Аймаг, нийслэл,  сум, дүүргийн нутаг дэвсгэрт хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах; | 0 | 100% | Энэ оны эхний хагас жилийн байдлаар тэжээлийн агуулах 1 120 м 2, хашаа хороо 8 1600м2,халдваргүйжүүлсэн бүс 1450м2 нийтдээ 3250 м2 -д халваргүйжүүлэлт хийсэн. Сумын хэмжээнд малын хорогдол гараагүй тул сэг зэм устгалын ажлыг хөрөнгө шийдүүлэн зохион байгуулаагүй. Малчидад өвөлжөө, хаваржааны ойр орчмыг цэвэрлэгээ  хийх талаар багийн хурлаар сургалт, танилцуулга хийж ажиллалаа. | 70% |
| 136 | 15. Хүнс, худалдаа үйлчилгээний салбарын хүрээнд: | 15.1. Сумдын хоршоо хөгжүүлэх сангийн зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагаа, зээлийн зарцуулалтад хяналт тавих | | 4 | Хоршоо хөгжүүлэх сангаас хагас жилийн байдлаар зээл олгоогүй. Хугацаа хэтэрсэн чанаргүй зээл байхгүй. Зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэж байна. Зээлдэгч нар зээлийн зориулалтын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.<br><br>Хавсралт : 5 зураг | 70% |
| 137 | | 15.2. Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг сайжруулах, чанаргүй зээлийн хэмжээг бууруулах, олгосон зээлийн мэдээллийг сар бүр | | 18% | Хоршоо хөгжүүлэх сангаас хагас жилийн байдлаар зээл олгоогүй. Хугацаа хэтэрсэн чанаргүй зээл байхгүй. Зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэж байна. | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | шинэчилж олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэх | | | | |
| 138 | | 15.3. Нийтээр тэмдэглэх баяр болох Цагаан сар, Хүүхдийн баяр, Наадам, Шинэ жилээр хүнсний аюулгүй байдлыг хангуулах | | 4 | Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиар суманд үйл ажиллагаа тогтмол явуулдаг дэлгүүр, зоогийн газар, караоке зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарт 2 удаагийн сургалт орж гарын авлага тараасан. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний эрүүл ахуйн улсын байцаагч н.Балдангомботой хамтарсан шалгалтыг 1 удаа зохион байгуулж хугацаа дууссан хүнсий бүтээгдэхүүнийг хурааж Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг устгалд оруулсан. Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн байцаагч нарын хяналтад мөн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарыг хамруулж шаардлагатай бичиг баримтын бүрдлийг шалгууллаа.<br><br>Хавсралт нийт : 3 Файл : 1 Зураг : 2 | 50% |
| 139 | | 15.4. Сумдын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн орчны дэлгэрэнгүй судалгаа хийх | | 2 | Шинэжинст суманд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгжүүдийн нэгдсэн дэлгэрэнгүй судалгааг 2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар гаргасан. Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААН 2, Өрхийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн 15, Худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа ААН 21, нийт хоршоо 18 үүнээс тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа хоршоо 9, Газар тариалан эрхлэгч тариаланч 21 байна. Судалгааг хавсралтаар хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 70% |
| 140 | | 15.5. Сумдын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг үзэсгэлэн худалдаанд идэвхтэй, хариуцлагатай хамруулах | | 3 | Малчид төлчдийн зөвлөгөөн 2025 оны 02 дугаар сарын 5-6-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Энэ үеэр сумын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулан “Цагаан сар 2025” үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд 1 хоршоо, 14 өрхийн үйлдвэрлэл эрхлэгч сүү цагаан идээ, оёдол, саван ноос ноолууран бүтээгдэхүүнээр оролцсон. Мөн аймгийн үзэсгэлэн худалдаанд сумын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч Т.Батжаргал уран зураг, хоол амтлагч жинчин нэрийн бүтээгдэхүүнээр оролцсон. | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хавсралт нийт : 6 Файл : 2 Зураг : 4 | |
| 141 | | 15.6. Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэлд орон нутгаас нийлүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх; | | 3 | Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд нийлүүлж байгаа бүтээгдэхүүний нэр төрөл, too хэмжээ өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн үзүүлэлттэй байна.<br><br>Хавсралт : 1 файл | 70% |
| 142 | 16. Байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд: | 16.1. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах газрын саналыг багийн иргэдийн Нийтийн Хурал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулах | 1 500 000 | 1 | Цагаан хаалга орчмыг орон нутгийн тусгай хамгаалалттай газарт авах судалгаа хийж Сумын ИТХ-ын хуралдаанд оруулсан | 50% |
| 143 | | 16.2. Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор нэгдсэн хяналт шалгалтыг зохион байгуулах | 1 000 000 | 10 100 | Засаг даргын баталсан удирдамжийн дагуу сумын иргэдийн төлөөлөл, ИТХ-ын төлөөлөгч, багийн засаг дарга нар, ЗДТГ-ын байцаагч нар орсон ажлын хэсэг “Эрдэнэ Монгол” ХХК-ний БОМТ-ийн хэрэгжилтэд 04 сарын 10-ны өдөр 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр хяналт шалгалт хийн ажилласан. “MCS интернейшнл” ХХК-ний үйл ажиллагаанд БОХУБ, иргэн Э.Давгасамбуу нартай хамт шалгалт хийн БОМТ-ний хэрэгжилтэд анхаарч ажиллахыг шаардсан. | 70% |
| 144 | | 16.3. Ус, усны сан бүхий газрын үхсэн малын сэг зэм, хог хаягдлын цэвэрлэгээ, устгал ариутгал | 400 000 | 4 | Манай сумын хувьд өвөлжилт, хаваржилт хүндрээгүй ус, усны сан бүхий газрын үхсэн малын сэг зэм үүсээгүй, уул уурхайн “Сэкер ресорсус монголиа” ХХК-тай хамтран 2,4 саруудад Цагаан хаалга, Задгайн булаг, Ямаан усны булаг гэсэн 3 булгийн орчны хог хаягдыг 2 удаа түүн 0,2, 0,3тн хог цэвэрлэн хогийн цэгт хүргэн ажилласан. | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | халдваргүйжүүлэлтийн ажлыг улирал бүр зохион байгуулах | | | | |
| 145 | | 16.4. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд энгийн болон онцгой хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах | 200 000 | 2 | Цагаан хаалгын рашааны онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэн самбар байршуулсан. | 70% |
| 146 | | 16.5. Гадаргын усны тоо бүртгэлийн ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах | 0 | 100 | Хэрэгжилт тайлагнах хугацаа болоогүй | 30% |
| 147 | | 16.6. Зэрлэг амьтны тархац нутаг малын бэлчээртэй давхацсан бүс нутагт мал, амьтны гаралтай халдварт өвчнөөс сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх | 150 000 | 2 | Сумын нутагт Ан амьтаны амьдрах орчинд идэш тэжээлийн хүрэлцээ, тоо толгойн судалгааг хийж эргүүл хяналтыг малын эмч Ц.Цэрэнбатаатай хамтран 2 удаа хийж ажиллалаа. Энэ ажлын үр дүнгээр нэн ховор болон ховор амьтадын судалгааг шинэчлэн баяжуулж гаргасан. | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 148 | | 16.7. Ган, зуд, цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах ажлыг хэрэгжүүлэх | 500 000 | 2 | . Ан амьтадын амьдрах орчныг сайжруулах ажлын хүрээнд 100 боодол өвс тавих ажлыг нутгийн иргэдийн нөхөрлөлүүдтэй хамтран ажиллаж бензин тосыг нь өгөх замаар өөрийн хамгаалдаг талбайд нь тавиулан ажилласан. Зараа 1-р багт Дөрвөлжин хайрхан, Уртын гол 2-р багт Толь булаг, Цагаан хаалга, Цармын уул, Агьт, Эрдэнэ шанд 3-р багт Баян сайр зэрэг газруудад тавин ажилласан. Эрдэнэ Монгол ХХК-аас төгрөгийн санхүүжилт. Энэ оны 03 сарын 19-20-ны өдрүүдэд Мазаалай баавгайд биотехникийн арга хэмжээ авч хорголжин тэжээл тавих ажлыг аймгийн Байгаль орчны газар, Сумын БОХУБ, Байгаль хамгаалагч, нутгийн иргэд, аймгийн гэрэл зурагчдын холбоо, ГИДЦГ-ын байгаль хамгаалагч нар хамтран авч хэрэгжүүлэн нийт 12 тэжээлийн бункерт хорголжин тэжээл тавин ажилласан. | 100% |
| 149 | | 16.8. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, дагалдах журмын хэрэгжилтийг хангаж, хуулийн хэрэгжилтийг 100 хувьд хүргэж нэмэгдүүлэх | 50 000 | 100 | Засгийн газрын 2022 оны 02- дугаар тогтоол, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө,батлуулан ажиллаж байгаа. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, орлого, гүйцэтгэл, ажил арга хэмжээ, зарцуулалтыг тайлагнан ажилласан. | 70% |
| 150 | | 16.9. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, зарцуулалтыг Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төсөв зардлын мэдээллийн санд | 70 000 | 7 | Сумын иргэдийн төлөөлөгчдийн 2024 оны 12 сарын 28-ны өдрийн хуралдаанаар 2025 онд хэрэгжүүлэх орон нутгийн суурь зардалд туссан байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэлэлцүүлэн хавсралтаар батлуулсан. | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | үнэн зөв төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулах. | | | | |
| 151 | | 16.10. Сар бүр бүх нийтийн цэвэрлэгээг тогтмол зохион байгуулах | | 12 | Эхэнхавцгай 4 дүгээр багийн Засаг даргын 2025 оны "Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай" 01 дүгээр захирамжаар их цэвэрлэгээ хийх хуваарьт газрыг тогтоон өгч сар бүрийн сүүлийн долоо хоногийн Пүрэв, Баасан гаригт сум нийтээрээ их цэвэрлэгээ хийж хэвшсэн.<br><br>Хавсралт нийт : 10 Файл : 2 Зураг : 8 | 70% |
| 152 | | 16.11. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх ажлыг иргэд, байгууллагад хэвшүүлэх | | 200 | Эхэнхавцгай багийн Засаг дарга сар бүр бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай захирамж гарган тухайн нутаг дэвсгэртээ сар бүр тогтмол зохион байгуулж, хагас жилийн байдлаар 4 удаа зохион байгуулж, нийт 12тн хог хаягдлыг хогийн цэгт хүргэсэн. Нийт 230 иргэн хамруулсан байна. Хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ангилан ялгах талаар ард иргэдэд уриалга гарган ажиллаж байна.<br>https://www.facebook.com/dawaa.gombosvren/videos/1407866613739770?idorvanity=103062496479393<br><br>Хавсралт : 3 зураг | 50% |
| 153 | | 16.12. Төвлөрсөн хог хаягдлын цэгийг хумиж цэгцлэх, камержуулах | 184 800 000 төгрөг | 100 | Хог хаягдлын цэгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор 2 удаа түрэх огшоох ажлыг гүйцэтгэсэн. Аж ахуйн нэгж 1, төрийн байгууллага 1, нийт 2 удаа арчлалт хамгаалалтыг хийж, камер байршуулсан зэрэг ажил үүрэг гүйцэтгэлээ. 2 дугаар улиралд хог хаягдлын цэгийг эмх цэгцтэй байлгах, ашиглалт хамгаалалтыг сайжруулахаар хог түрэх, огшоох зорилгоор Орон нутгийн хөгжлийн сангийн 184 800 000 төгрөгийн хөрөнгөөр ковш трактор худалдан авлаа.<br><br>Хавсралт нийт : 6 Файл : 1 Зураг : 5 | 70% |
| 154 | | 16.13. Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоог | 328.090.640 төгрөг | 15 | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Спорт цэцэрлэгт хүрээлэнгийн орчимд Нийтийн бие засах газар буюу Эко нойлтой болох тендер зарлаж гүйцэтгэгчээр “Хорол багана констракшн” ХХК нь шалгаран 328090640 төгрөгийн гэрээ байгуулсан. Ажил 6 дугаар сарын 25-наас эхлэхээр төлөвлөгдсөн. | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлэх | | | Хавсралт : 1 файл | |
| 155 | | 16.14. Стандартын шаардлага хангахгүй нүхэн жорлонг буулгах | | 15 | Стандартын шаардлага хангахгүй сумын төвийн гудамжинд байгаа 3 нүхэн жорлонг буулгах мэдэгдэл өгсөн. Гудамж хороолол цэвэр байлгах чиглэлээр төлөвлөгөө гаргаж захирамжаар батлуулан хэрэгжүүлж эхлээд байна. | 50% |
| 156 | | 16.15. Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг угтан сургалт, нөлөөллийн олон талт арга хэмжээг өргөн зохион байгуулж, иргэдэд экологийн боловсрол, уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгөх | | 30 | Байгаль орчны тэмдэглэлт өдөр Мазаалай баавгайн бараpхалт өдөр, Дэлхийн усны өдрийн хүрээнд сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж эссэ бичлэг, зургийн уралдаан, олон нийтийг хамруулах үүднээс софт, волейболын тэмцээн зэргээр дамжуулан мэдлэг мэдээлэл олгох ажлууд өрнүүлэн ажилласан. Нийт 320 гаруй иргэн хамрагдсан байна.<br><br>Хавсралт : 3 зураг | 70% |
| 157 | | 16.16. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын хэмжээнд хамгаалалтын ойн зурвас байгуулах, мод тарих боломжит газрын судалгааг гарган 2026 оны газар зохион | | 1 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын хэмжээнд хамгаалалтын ойн зурвас байгуулах, мод тарих боломжит газрын судалгааг гарган 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулах ажил Хотын хөгжлийн төлөвлөгөө батлагдсаны дараа хийгдэхээр хүлээгдэж байна | 30% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулах | | | | |
| 158 | | 16.17. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ойжуулалт, ногоон байгууламжийн талбайн худаг, усалгааны асуудлыг шийдвэрлэх | | 100 | Сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр Байгаль орчны зардлаас 18450000 төгрөг төсөвлөсөн бөгөөд иргэнтэй гэрээ байгуулан модны талбайн услагаа, арчилгааг хариуцуулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр ногоон байгууламжид 52 сая төгрөг суулган тендер шалгаруулан ажил үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд цэцэрлэгт хүрээлэнгийн модны усалгаанд дуслын услалтын систем суурилуулах, модны талбайн худгийн барилгыг шинэчлэх зэрэг ажлууд хийгдээд байна. Орчны тохижилтод 320 сая төгрөг зарцуулахаар төсөв батлагдсан, тендер зарлагдан хэрэгжүүлэх шатандаа байна. | 70% |
| 159 | | 16.18. Хавар намрын улиралд бүх нийтээр мод тарих арга хэмжээг зохион байгуулах | | 75 | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр ЭрдэнэМонгол ХХК 2024 онд 5 иргэн, 2025 онд 5 иргэнтэй гэрээ байгуулан урамшуулан ажиллаж байна. Сумын хэмжээнд 2025 оны хагас жилд 145000 ширхэг мод газрын хөрсөнд суулган таригдсан дүн мэдээтэй байна.<br><br>Хавсралт : 12 зураг | 70% |
| 160 | | 16.19. Ургамлын мониторинг судалгаа хийх | | 100 | Ургамлын судалгаа хийх зориулалтаар төрийн байгууллагаас 2 сая төгрөг төсөвлөсөн бөгөөд байгаль хамгаалагчид хариуцан ажиллахаар төлөвлөсөн. Ургамлын судалгаа ургамлын гарц боловсрох үеэр буюу намар хийгдэнэ. | 50% |
| 161 | 17. Газрын харилцаа, дэд бүтцийн хүрээнд: | 17.1. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах, тодотгох талаар аймаг, орон нутгийн удирдлагуудыг мэдээ, танилцуулгаар хангаж төлөвлөгөөний | | 100 | Иргэдийн хурал, Сумын Засаг дарга нарт сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх талаар мэдээлэл өгч 2025 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 300 төгрөгөөр сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийлгэхээр төсөвт суулгасан. Сумын хөгжлийн ерөний төлөвлөгөөтэй холбоотой ажлаар аймгийн хөгжлийн бодлого хөрөнгө оруулалтын хэлтэс, газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас мэдээлэл авссан. Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас боловсруулсан ажлын даалгаврыг Засаг даргад танилцуулан, тендер зарлуулахаар ажлын хэсэг хүлээлгэн өгсөн. Тендер зарлагдаж 2025 оны 06 дугаар сарын 24 нд нээхээр байна. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | зардлыг 2026 оны сумын төсөвт суулгах ажлыг зохион байгуулах | | | | |
| 162 | | 17.2. Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах зардлыг 2026 оны сумын төсөвт суулгах | 300000000 | 100 | 2025 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 300 төгрөгөөр сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийлгэхээр төсөвт суулгасан. | 100% |
| 163 | | 17.3. Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон талбайн хэмжээгээр газар ашиглах эрхийг баталгаажуулан мэдээллийн санд бүртгэж, нэгж талбарт газрын төлбөр тооцож, ногдуулалт үүсгэх | | 19 | Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон талбайн хэмжээгээр газар ашиглах эрхийг баталгаажуулан мэдээллийн санд бүртгэхийг тул тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, Засаг даргын захирамж гарсаны дараа мэдээллийн санд баталгаажиж, газрын төлбөрийн ногдолыг үүсгэдэг. Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон газрыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанд оруулсан боловч дэмжигддэггүй шалтгаанаар тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдах боломжгүй болоод байна. | 30% |
| 164 | | 17.4. Газарт учруулсан хохирлын тайлан (ГНСТ-9 маягт)-аас маш хүчтэй доройтсон газрыг тодорхойлох, нөхөн сэргээх ажлыг | | Нөхөн сэргээсэн газрын хэмжээ | хөрөнгийн асуудал шийдэгдээгүй | 0% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хөрөнгө гарган зохион байгуулах | | | | |
| 165 | | 17.5. Газрын харилцааны бүтээгдэхүүн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор ухаалаг төхөөрөмж /киоск/-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах төхөөрөмж /киоск/-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах | | 1 | УИХ-ын гишүүн Д.Жаргалсайхан -ны дэмжлэгээр Төрийн үйлчилгээний киоск төхөөрөмжтэй болж үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Иргэд үйлчилгээ авч байна. | 100% |
| 166 | | 17.6. Аймгийн ГХБХБГ-ын архивт нэгж талбарын хувийн хэргийг хүлээлгэж өгөх | | 100 | Газар өмчлөлийн хувийн хэргийн цаасан бүрдлийн бүрдүүлэн архивт өгөхөөр ажиллаж байна. | 50% |
| 167 | | 17.7. Газар зүйн нэрийн тодруулалт хийх ажлыг зохион байгуулах | 19800000 | 100 | Газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг Оюу Имиж ХХК хийж гүйцэтгүүлсэн. Сумын иргэдийн төлөөлөгчдийн 2024 оны 09 дүгээр сарын 24 өдрийн хуралдаанаар танилцуулж Батлагдаагүй болон нэр зөрүүтэй орсон газар зүйн нэрсийг нэмж батлуулахаар Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаас 2024 оны 09 дүгээр сарын 24 өдрийн 120 дугаар тогтоолоор гаргаж аймаг, болон улсын их хуралд өргөн барихаар Засаг дарга, Оюу Имиж ХХК-д даалгасан. Ажлын даалгаварт туссан ажлуудыг хүлээн аваагүй байна. | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 168 | | 17.8. Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг 4 дүгээр улиралд багтаан тайлагнах | | 100 | хугацаа болоогүй | 30% |
| 169 | | 17.9. Монгол Улсын иргэнд 2026 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтын саналыг нэгтгэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, 2025 оны 12 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх | | 1 | хугацаа болоогүй | 30% |
| 170 | | 17.10. Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг зохион байгуулах | | 314 | Бэлчээрийн фотомониторингийн ажлыг 8 сард зохион байгуулахаар төлөвлөгөө гарсан. | 30% |
| 171 | 18. Хөрөнгө оруулалтын салбарын | 18.1. Төрийн худалдан авах ажиллагааг сум тус | | 100 | Тухайн онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл хөтөлбөрөөс 14 төсөл арга хэмжээ батлагдсан зураг төсөв, ажлын даалгавар дагуу хуулийн хугацаанд нь харьцуулалт болон нээлттэй тендер | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хүрээнд: | бүр батлагдсан зураг, төсөв, техникийн тодорхойлолтын дагуу 2025 оны 05 дугаар сарын 01-ээс өмнө зохион байгуулж дуусгах | | | шалгаруулалтын аргаар зохион байгуулсан. 2 төсөл арга хэмжээ нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар төсөвт зохицуулалт хийгдэх байдлаар хүлээгдэж байна. | |
| 172 | | 18.2. Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын саналыг сүүлийн 2 жилийн хугацаанд батлагдсан ТЭЗҮ, зураг төсөвтэй ирүүлэх | | 100 | Суманд хийгдэх төсөл, арга, хэмжээ тус бүрт нь зураг төсвийн мэргэжлийн байгууллагаар хийж баталгаажуулсан ажлын зураг, төсөв, ажлын даалгавар,техник эдийн засгийн үзүүлэлт зэргийг гаргуулж хуулийн дагуу тендер шалгаруулалтыг үр дүнтэй зохион байгуулж байна. | 100% |
| 173 | | 18.3. Орон нутгийн хөгжлийн сан /цаашид ”ОНХС” гэх/-хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг батлахдаа Төсвийн тухай хуулийн 60.3 дахь заалтыг баримталсан байх. | | 100 | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөтөлбөр,төсөл, арга хэмжээг төсвийн тухай хуулийн 60.3.1, 60.3.2, 60.3.3, 60.3.3, 60.3.4, 60.3.5, 60.3.6 дахь заалтуудыг баримтлан Сумын ИТХ-н 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 14 тоот тогтоолын 2-р хавсралтаар батлагдсан маягтын дагуу боловсруулж батлуулж ажилласан байна. Хавсралт файлаар 2025 оны төсөв баталсан тогтоол хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 174 | | 18.4. Орон нутгийн хөгжлийн сангийн | | 100 | Тухайн онд хийж хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд сумын 4 багийн 18 -аас дээш насны иргэдээс нийт 90 хувийн санал авч багуудын | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэлэлцүүлэхэд санал өгөх эрх бүхий иргэдийн 80-аас доошгүй хувийн оролцоог хангасан байх | | | ИНХурлаар хэлэлцүүлж хурлын тогтоол шийдвэрээр баталгаажуулан эрэмбэлэн ажилласан. | |
| 175 | | 18.5. ОНХС-ийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн болон тус сангийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг ОНХС-ийн Удирдлага мэдээллийн систем /htts://tusuv-oronnutag.mof.gov.mn/-д тухай бүр оруулах ажлыг зохион байгуулж тус сангийн үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт тавих боломжийг хангах | | 100 | ОНХС-ийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн болон тус сангийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг ОНХС-ийн Удирдлага мэдээллийн систем /htts://tusuv-oronnutag.mof.gov.mn/-д тухай бүр оруулж нийт 21 төсөл хөтөлбөрөөс бүрэн хэрэгжсэн 6 төсөл арга хэмжээ, хэрэгжилт дутуу 6 төсөл арга хэмжээг тус тус байршуулж ажилласан байна. | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 176 | | 18.6. Шинээр баригдах барилга байгууламж, гадна засвар, тохижилтын ажлыг тухайн жилийн 10 дугаар сарын 15-аас хойш хийхгүй байх. | | 100 | Тухайн онд хийж хэрэгжүүлэх 4 багийн төсвийн их засвар, Эмчийн байр засварлах ажлууд бүрэн дуусч ажлын хэсэг хүлээн авч ажилласан ба Спорт заалны их засвар, 80 хүүхдийн дотуур байрны их засвар, Эко нойлтой болох, Ногоон байгууламж нэмэгдүүлэх зэрэг ажлууд 2024 оны 09 дүгээр сарын 01 дотор хүлээн авахаар гэрээнд тусгаж ажиллаа. | 70% |
| 177 | | 18.7. Барилга байгууламж барих, их засвар, гадна тохижилтын ажлуудад мэргэжлийн байгууллагын хяналтыг тухай бүр хийлгэх | | 100 | Барилга байгууламж барих, их засвар, гадна тохижилтын ажлуудад мэргэжлийн байгууллагын хяналтыг төсөл арга хэмжээ тус бүрт нь хийлгэхээр төлөвлөж байна. Одоогоор ажлууд хийгдээгүй байна. 1 төсөл арга хэмжээнд мэргэжлийн байгууллагын хяналт хийгдсэн байна. | 30% |
| 178 | | 18.8. Тухайн онд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний ажил хүлээлцэх комисст харьяалах сум, багийн Засаг даргыг заавал оруулж ажлыг хүлээж авах | | 100 | Тухайн онд хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрүүдийн ажил хүүлээлцэх комисст багийн засаг дарга нарыг биечлэн оролцуулж ажиллаж байна. Ажил хүлээлэх комисс томилсон шийдвэрийг хавсралт файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 2 файл | 70% |
| 179 | | 18.9. Төсөл арга хэмжээний төсөвт суусан хяналтын зардлыг холбогдох байгууллагуудад шилжүүлэн | | 100 | Тухайн онд хийж хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөвт суусан хяналтын зардлыг холбогдох байгууллагууд шилжүүлэх зардал одоогоор хэрэгжээгүй байна. Хугацаа болоогүй байна. | 30% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хяналтыг хийлгэх | | | | |
| 180 | | 18.10. Хуульд заасны дагуу төсөл, арга хэмжээнээс “Чанарын баталгаа”-ны зардлыг суутган аймгийн холбогдох дансанд байршуулах | | 100 | Хугацаа болоогүй байна. | 30% |
| 181 | | 18.11. Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг нэмэгдүүлэх | | 100 | Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг нэмэгдүүлэх талд дээр анхаарч Болд баатар даргатай гэрээ байгуулж зөвлөн туслах үйлчилгээ авч ажиллаж байна. | 50% |
| 182 | | 18.12. Өмч хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах | | 100 | Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар өмч хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах тогтоол гаргаж батлуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байгаа тул хугацаа болоогүй байна. | 30% |
| 183 | 19. Төсөв, санхүүгийн ажил үйлчилгээг хэрэгжүүлэх хүрээнд: | 19.1. Улс, орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг нэр төрөл тус бүрээр жигд ханган биелүүлж, төсвийн | Үйл ажиллагаагаар | 16 149.4 | Татварын орлогын төлөвлөгөөг сар бүр жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллалаа. Тухайн онд 4055422.0 мян.төг-ийн орлогын төлөвлөгөөтэй. Үүнээс Оны эхний 5 сарын байдлаар 458060.0мян.төг-ийн орлого төвлөрүүлэхээс 1175685.6 мян.төг-ийн орлого төвлөрүүлж орлогын төлөвлгөөний тэнцлийг 256 хувиар ханган биелүүлсэн. Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид, тэдгээрийн туслан гүйцэтгэгчдийг сумд татварын төрлөөр бүртгүүлэн орлогыг төвлөрүүлж байхаар албан хүсэлтийг өгч байна.Орлогын төлөвлөгөөг биелүүлэх | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | орлогын бааз суурийг нэмэгдүүлэх | | | боломжтой.<br><br>Хавсралт : 1 файл | |
| 184 | | 19.2. Хөрөнгийн татвар төлөгчдийн мэдээллийн зөрүүг арилгаж, орлогыг нэмэгдүүлэх /үл хөдлөх, галт зэвсэг, газар, авто тээвэр/ | Шатахууны зардал гарсан | 2,687.5 | Энэ онд үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараар 2275.8 сая.төг-ийн орлогын төлөвлөгөөтэй. Эхний улиралд 388549.2 мян.төг-ийн орлого төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн. Урьд оны өртэй 1 татвар төлөгчийн 241252 өрийн үлдэгдэл байгаа. Эрдэнэмонгол ХХК-ийн үл хөдлөхийн ногдлыг нэмэгдүүлэх, урьд оны өрийг барагдуулах талаар 2 удаа ажлын хэсгийн хамт очиж ажиллан зөвлөмж хүргүүлсэн. Хүлээгдэж байна.<br><br>Хавсралт : 5 зураг | 70% |
| 185 | | 19.3. Татварын хууль тогтоомж, цахим системийн талаар иргэд, малчид, шинээр байгуулагдсан хоршоодод сургалт мэдээлэл хийх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаагаар | 4 400 | Сургалтын төлөвлөгөөг хагас жилээр гарган батлуулсан. Үүний дагуу ХХОАТ, Татварын цахимын шинэчлэлийн тухай, ААНОАТ-ын хуулийн шинэчлэлийн талаар танхимын болон ажлын байрны 5 удаагийн сургалтад 380 гаруй иргэн хамрагдсан байна. Гарын авлагыг 90 гаруй өрхөд тараасан. Сургалтын бүртгэлийг маягтын дагуу бүртгэсэн.<br><br>Хавсралт : 7 зураг | 70% |
| 186 | | 19.4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, санхүүгийн мэдээллийг олон нийтэд ил тод болгох (хавсралтаар) | | 100 | Төсвийн байгууллагууд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган хугацаанд нь мэдээллээ байршуулж улирал бүр шилэн дансны тайлангаа холбогдох хавсралт файлуудын хамтаар илгээж ажиллаж байна. Мөн шалгалтаар өгсөн зөвлөмжийг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж байна. Шилэн дансны тухай хуулийн дагуу эхний хагас жилд ЗДТГ, ИТХ-ын мэдээллэх 146 мэдээллээс хугацаа хоцроон мэдээллэсэн – 4, хугацаандаа мэдээллэсэн – 142 ОНХС, Төсвийн ерөнхийлөн захирагчийн мэдээллэх 76 мэдээллээс хугацаа хоцроон мэдээллэсэн – 11, хугацаандаа мэдээллэсэн – 65 байна. https://auth.itc.gov.mn/auth<br><br>Хавсралт : 1 файл | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 187 | | 19.5. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, суманд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийг цахим төлбөрийн баримтын системд бүрэн холбож, төлбөрийн баримтын олгож хэвших | Үйл ажиллагаагаар | 75% | НӨАТ-ын хуулийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрэн хэрэгжүүлэхийг зорин хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Суманд үйл ажиллагаа явуулдаг 31 татвар төлөгч төлбөрийн баримтын системд бүрэн холбогдсон. Татвар төлөгчдийн ибаримт олгож байгаа эсэхийг татвар төлөгч бүрээр ТУНС-ээс сар бүр хянаж хэдэн төгрөгийн баримт шивсэн, үнийн дүнд хяналт тавин татвар төлөгч бүртэй холбогдон баримтаа тогтмол олгож байхыг шаардан ажилладаг. Төрийн байгууллагуудтай гэрээгээр хамтран ажилладаг татвар төлөгчид төлбөрийн баримт бүрэн ашиглаж хэвшсэн. Иргэдэд татвар төлөгчдийн ажлын байранд байрлуулсан. QR кодыг хэрхэн ашиглах талаар, цахим төлбөрийн баримтаа авч байх талаарх мэдээллийг олон нийтийн цахим сүлжээ ашиглан сурталчилж байна. | 50% |
| 188 | | 19.6. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.2, 8.9.3 дахь заалтуудын дагуу төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь гаргах | | 100 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан болон төсвийн байгууллагын жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл тайлан балансыг хуулийн хугацаанд нь төрийн аудитын байгууллад хүргүүлж ажилласан байна. Аудитын байгууллагаар хянан баталгаажуулсан санхүүгийн тайлан балансыг Санхүү төрийн сангийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогчид нэгтгүүлэн ажиллаа. | 100% |
| 189 | | 19.7. “Баянхонгор аймгийн 2025 оны төсөв батлах тухай” Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 4/28 дугаар тогтоолын 5 дугаар заалтын дагуу Сумын төсвөөс | | 2,174.8 | Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 4/28 дугаар тогтоолын 5 дугаар заалтын дагуу Сумын төсвөөс Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,2,3,4-р саруудад 724,943,600 / Долоон зуун хорин дөрвөн сая есөн зуун дөчин гурван мянга зургаан зуу/ төгрөгийг төвлөрүүлж ажилласан байна. | 30% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг хуваарийн дагуу бүрэн төвлөрүүлэх /сая.төг/ | | | | |
| 190 | | 19.8. Тухайн сумд бүртгэлтэй ААН, байгууллагын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд www.e-balance.mof.gov.mn цахим хуудсаар тайлагнасан байх | | 83% | Шинэжинст сумын хэмжээнд санхүүгийн тайлан илгээх 54 ААН, байгууллага байгаа. Тус ААН байгууллагуудтай хамтран тайлангуудыг www.e-balance.mof.gov.mn цахим хуудсаар хуулийн хугацаанд илгээсэн. Мөн эхний улирлын татварын тайлангуудыг холбогдон илгээлгэсэн. Хагас жилийн тайланг мэдээллэх хуулийн хугацаа нь 2025.07.15-ны дотор байдаг. | 100% |
| 191 | | 19.9. Хяналт шалгалт, дотоод аудитаар өгсөн зөвлөмж түүний хэрэгжилтийг хангах | | 95% | Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайланд хийсэн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хүрээнд ажлын төлөвлөгөө боловсруулж ажиллаж байна. | 30% |
| 192 | | 19.10. Дутагдуулсан маргаантай хөрөнгийн эзэн холбогдогчийг мөрдөх эрхтэй байгууллагад хандан тогтоолгох, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан | | 100% | Хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх авлага үүсээгүй байна. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаж, Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллах. (хавсралтаар) | | | | |
| 193 | | 19.11. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Баянхонгор аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 2.3.7 Улсын хэмжээнд нэгдсэн журмаар хэрэгжүүлж байгаа “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим систем” -ийн программ хангамжийг ашиглалтад бүрэн нэвтрүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бий болгох ажлыг тухайн аймаг, сумдаа зохион | | 100% | “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим систем” -ийн программ хангамжийг ашиглалтад бүрэн нэвтрүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бий болгох ажлыг https://umch.sgov.mn/ сайтад төсөвт албан газрууд хуулийн хугацаанд нь бүрэн оруулж ажилласан байна. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулж, удирдлага, зохицуулалтаар ханган, хэрэгжүүлж ажиллах. | | | | |
| 194 | | 19.12. Албан ёсны статистик 39 мэдээллийн үнэн зөв байдалд тогтмол шалгалт хийж, түүний бодит байдлыг хангах. | Улсын төсвийн хөрөнгөөр 1,666,624 төгрөгөр санхүүжүүлсэн. | 20/85 | Аймгийн Засаг даргын 2025.01.17-ны А/24 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар баталсан мэдээ, тайлангийн график батлах тухай албан бичгийн дагуу мэдээллэх ёстой 39 мэдээ, тайланг хуулийн хугацаанд https://medee.app.nso.mn/, https://sudalgaa.1212.mn/ цахим систем байршуулсан. Мөн хагас жилийн малын түүвэр судалгааг 2025.06.04-10-ны хооронд зохион байгуулан Livestock программд бүрэн шивж оруулсан.<br>Хавсралт : 4 зураг | 90% |
| 195 | | 19.13. Тухайн сум орон нутгийн хөрөнгөөр хэрэгжих худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар журамд зааснаар худалдан авах ажиллагааны цахим систем/ tender.gov.mn/ -ээр тайлагнах | | 100% | Тухайн онд хийж хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн ажлын төлөвлөгөөг батлагдсан маягтын дагуу боловсруулж сумын засаг даргаар батлуулж төрийн худалдан авах ажиллагааны /tender.gov.mn/ сайтад байршуулсан . Хавсралтаар ажлын төлөвлөгөөг хавсаргав.<br>Хавсралт : 1 файл | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 196 | | 19.14. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулж, ажлын явцад хяналт тавьж, ажил дууссан тухай бүр илтгэх хуудсаар аймгийн Засаг даргад тайлагнаж ажиллах. | | 100 | Энэ онд Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ байхгүй. | 100% |
| 197 | | 19.15. Захиалагч хуульд заасан үндэслэлээр гэрээ шууд байгуулах арга болон нэг эх үүсвэрээс худалдан авалт хийсэн тохиолдолд хуулийн 48 дугаар зүйлийн 48.7-д “Захиалагч энэ хуулийн 35,36 дугаар зүйлд заасан дагуу гэрээ | | 100% | Тухайн онд шууд гэрээ байгуулах 6 төсөл хөтөлбөрөөс 3 төсөл арга хэмжэнд гэрээ байгуулж авлигатай тэмцэх газарт хүргүүлж ажиллаа. | 30% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулсан тохиолдолд гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт гэрээ байгуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх. | | | | |
| 198 | | 19.16. Төсөвт байгууллагуудын ажилтнуудыг худалдан авах ажиллагааны чиглэлээр сургаж, мэргэшүүлэх | | 11 | иргэний төлөөлөл 1, төсвийн байгууллагын 2 албан хаагч сургалтад хамрагдаж шалгалт өгсөн хэдий ч 2 албан хаагч шалгалтад тэнцээгүй, 1 хүн тэнцэж А3 сертификатаа авсан байна. | 50% |
| 199 | | 19.17. Санхүүгийн албаны ажилтныг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангах, боловсон хүчний бодлого боловсруулж мөрдөж ажиллах (хавсралтаар) | | 100% | Санхүүгийн албаны ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоог хангах орон нутагт төвлөрөх орлогын бааз суурийг нэмэгдүүлж ажилтан албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 80 хувь хүртэл олгон урамшуулан ажиллаж байна | 100% |
| 200 | | 19.18. Төрийн сангийн үйл ажиллагаанд | | Бага эрсдэл | Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомж, заавар журмын хэрэгжилтийг хангах тус сумын төрийн сангийн үйл ажиллагааны эрсдлийг үнэлэн бууруулан ажиллаж байна. | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | мөрдөгдөж буй хууль тогтоомж, заавар журмын хэрэгжилтийг хангах замаар төрийн сангийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулж ажиллах (хавсралтаар) | | | Хавсралт : 1 файл | |
| 201 | 20. Батлан хамгаалах салбарын бодлого, үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих бодлогын хүрээнд: | 20.1. Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг орон нутагт сурталчлах | 22.000.000 төгрөг | 12 | Батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлж сумын хэмжээнд 2025 оны цэргийн тоо бүртгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 16-24-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж хяналтын тоог 98 хувь хангаж ажиллав. Мөн 2025 оны 1-р ээлжийн цэрэг татлагыг 2025.04.16-17-нд зохион байгуулж хяналтын тоог 100% хангаж, цэргийн штабтай холбогдох тооцоог бүрэн хийж ажиллав. Цэргийн насны залуучуудад эх орон сэтгэлгээ төлөвшүүлэх, цэргийн албыг сурталчилах ажлыг зохион байгуулж хуулийн сургалт 1 удаа 62 хүн, гарын авалга 1 удаа 62 хүнд тус тус хүргэж ажиллав. Мөн хилийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Хилийн цэргийн 0166 дугаар ангид үйл ажиллагааны дэмлэг 20.000.000 төгрөг, цэрэг эрсийн сургалт хүмүүжлийн өрөөний тохижилтод 1.000.000 төгрөг тус тус шийдвэрлэж ажиллав. Хилийн цэргийн 0166 дугаар ангийн цэргийн Тангаргын баярт сумын ИТХ-ын дарга Н.Сайханбаяр, засаг дарга Л.Батхуяг, Тамгын газрын дарга Э.Амгаланбаяр нар 2025.06.11-нд хүрэлцэн очиж хонгор нутгаас алба хааж буй 99 цэрэгт аймаг орон нутгийн нэрийн өмнөөс хүндэтгэл үзүүлж, амжилт хүслээ. | 80% |
| 202 | | 20.2. “Эх оронч Монгол-Их сэргэлтийн жил”-ийн хүрээнд иргэдэд эх орон үзэл олгох ажил арга хэмжээ зохион байгуулах | Сургалт, гарын авлага 150.000 төгрөг Сургачид торгон хилд арга хэмжээ 1.500.000 | 12 | Цэргийн насны залуучуудын дунд хуулийн сургалт, гарын авлага 62 хүнд тараав. ЕБСургуулийн 9 дүгээр ангийн сурагчдыг "Сурагчид торгон хилд" арга хэмжээнд 2025.09 дүгээр сард оролцуулхаар төлөвлөн ажиллаж байна. Уг арга хэмжээний үеэр сурагчдыг сумын нутагт байрлах Сэгс цагаан богдын заставын хилчин дайчдын аж амьдралтай танилцуулж нутаг усны болон улс орны тусгаар тогнол, халдашгүй дархан байдлыг хэрхэн хамгаалдаг ямар их үнээр олддог талаар сургалт ухуулга хийж, цэрэг эх орны сэдэвт уран сайхны киног хээрийн байрдалд хоноглох үедээ үзүүлж эх орноороо бахархах сэтгэлийг бадраадаг | 80% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төгрөг | | уламжлалтай. Энэхүү арга хэмжээ 3 дахь жилдээ зохион байгуулагдана. | |
| 203 | | 20.3. Цэрэг татлагын товчоогоор орох иргэдийн тоо, хамрагдалтыг нэмэгдүүлэх | 150.000 төгрөг | 100% | Цэрэг татлагын товчоогоор орох иргэдийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2025.04.16-нд цэргийн насны залуучуудад сургалт, орой нь АХА тэмцээн, нийтийн цэнгээнт бүжиг, нөлөөллийн ажил зохион байгуулав. | 70% |
| 204 | | 20.4. Цэргийн насны залуусыг эрүүлжүүлэх, үр дүнг нь тооцох | | 360 | Цэрэг татлагаар өвчний улмаас чөлөөлөгдсөн залуучуудыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулан эрүүлжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. | 30% |
| 205 | | 20,5. Аймгийн цэрэг татлагын товчооноос өгөгдсөн тоон даалгаврыг биелүүлэх | 360.000 төгрөг Засаг даргын нөөц | 100% | аймаг, сумын засаг даргын захирамжаар сумын хэмжээнд цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлыг хэсгийг сумын ЗДТГ-ын даргаар ахлуулан зохион байгуулж 2025.04.16-нд цэрэг татлагын ажлыг зохион байгуулан хяналтыг тоог 100 хувь хангаж ажиллав. | 100% |
| 206 | | 20.6. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг хангасан иргэдийн төлбөрийг төрийн санд төвлөрүүлэх | | 116 | Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр дүйцүүлэн хаах насны болзол хангасан иргэдийн 70 хувийг төрийн сангийн холбогдох дансанд бүрэн төвлөрүүлж хаягндаа байхгүй, гадаадад ажиллаж байгаа зэрэг иргэдэд мэдэгдэл хүргүүлэн ажиллаж байна. | 70% |
| 207 | | 20.7. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийг тодотгох, нөөц бүрдүүлэх | Засаг даргын нөөц 5.000.000 төгрөг | 100% | Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөнд тодотгол хийж томилгоот нэгжүүдийг бэлэн байдалд оруулан ажиллаж байна. | 100% |
| 208 | | 20.8. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн | | 100 | Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хүсэлт өгсөн иргэдийг холбогдох хууль дүрэм журмын дагуу элсүүлэн ажиллаж байна. 2025 оны 05 дугаар сард зохион | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хааж байгаа иргэдийн сургалтад алба хаагчдыг бүрэн хамруулах | | | байгуулагдсан сургалтанд 2 иргэнийг бүрэн хамруулж ажиллаж байна. | |
| 209 | | 20.9. Бэлтгэл үүрэгтний сургалтуудад иргэдийн хамралтыг нэмэгдүүлэх | 140.000 замын зардал | 180 | Бэлтгэл үүрэгтний төлөвлөгөөт сургалтад 2025.05 дугаар сард хилийн цэрэгт алба хаасан 2 иргэнийг хамруулан ажиллав. | 100% |
| 210 | | 20.10. Цэрэг-Спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулан шалгарсан баг, тамирчдыг аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцуулах | | 27 | сумын хэмжээнд 9-н жилийн сургалтын хөтөлбөртэй тул ахлах ангийн сурагчдийн дунд явагддаг дөл тэмцээнд оролцох боломжгүй байдаг | 50% |
| 211 | | 20.11. Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг орон нутагт сурталчлах | | 12 | Зүйл заалт давхардаж орсон байгаа тул хасаж өгнө үү. | 100% |
| 212 | | 20.12. “Эх оронч Монгол-Их сэргэлтийн жил”-ийн хүрээнд иргэдэд эх орон үзэл олгох ажил арга хэмжээ | | 12 | Зүйл заалт давхардаж орсон байгаа тул хасаж өгнө үү. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | зохион байгуулах | | | | |
| 213 | | 20.13. Цэрэг татлагын товчоогоор орох иргэдийн тоо, хамрагдалтыг нэмэгдүүлэх | | 100% | Зүйл заалт давхардаж орсон байгаа тул хасаж өгнө үү. | 100% |
| 214 | | 20.14. Цэргийн насны залуусыг эрүүлжүүлэх, үр дүнг нь тооцох | | 360 | Зүйл заалт давхардаж орсон байгаа тул хасаж өгнө үү. | 100% |
| 215 | | 20.15. Аймгийн цэрэг татлагын товчооноос өгөгдсөн тоон даалгаврыг биелүүлэх | | 100% | Зүйл заалт давхардаж орсон байгаа тул хасаж өгнө үү. | 100% |
| 216 | | 20.16. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг хангасан иргэдийн төлбөрийг төрийн санд төвлөрүүлэх | | 116 | Зүйл заалт давхардаж орсон байгаа тул хасаж өгнө үү. | 100% |
| 217 | | 20.17. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийг тодотгох, нөөц бүрдүүлэх | | 100% | Зүйл заалт давхардаж орсон байгаа тул хасаж өгнө үү. | 100% |
| 21 | | 20.18. Цэргийн | | 100 | Зүйл заалт давхардаж орсон байгаа тул хасаж өгнө үү. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | | албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийн сургалтад алба хаагчдыг бүрэн хамруулах; | | | | |
| 219 | | 20.19. Бэлтгэл үүрэгтний сургалтуудад иргэдийн хамралтыг нэмэгдүүлэх | | 180 | Зүйл заалт давхардаж орсон байгаа тул хасаж өгнө үү. | 100% |
| 220 | 20. Батлан хамгаалах салбарын бодлого, үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих бодлогын хүрээнд: | 20,20. Цэрэг-Спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулан шалгарсан баг, тамирчдыг аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцуулах | | 27 | Зүйл заалт давхардаж орсон байгаа тул хасаж өгнө үү. | 100% |